

**МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГОД  
ЗААСАН СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, БАЙДАЛ**

**Хэнтий аймаг**

№	Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод заагдсан стратегийн зорилтуудын нэр, заалтын дугаар	Хэрэгжилт	Биел элтийн хувь
0	1	2	3
<b>1.0. Байгаль орчны салбар</b>			
1.	Байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсооно 6.0	2009 онд Хэрлэн суманд хог хаягдал зайлуулах түр цэгийг 8 газарт байгуулаад байна. Аймгийн хэмжээнд хог хаягдал цэвэрлэх, дарж булах ажилд 78 машин техникийг хамруулан 24,9 сая төгрөг зарцууллаа. 2009 онд Өндөрхаан хотод агаарын чанарын хяналтын харуулыг 160 орчим сая төгрөгийн өртөгтэй хоногт 3 удаа агаарын чанарын ажиглалт судалгаа хийж байна. Мөн 120,0 сая төгрөгийн өртөгтэй шар шороон шуурганы мониторингийн автомат станцыг байгууллаа.	30
2.	Газар, газрын хэвлийн баялагийг зохистой ашиглах нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ 6.0	Байгалийн унаган төрхийг хадгалах, түүний нөөц баялагийг хамгаалах, түүх соёлын дурсгалт зүйлсийг нь хадгалж хамгаалах, мөн аялал жуулчлал хөгжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд нийт 9 газрын 50887 га, сумын хэмжээнд 66 газрын 447056 га-г тусгай хамгаалалтанд авснаар аймгийн нийт нутгийн 0.06 хувь нь тусгай хамгаалалттай газарт бүртгэгдээд байна. Хэнтий аймагт ашигт малтмалын хайгуулын 255 тусгай зөвшөөрөл, ашиглалтын 55 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгаа нийт газар нутгийн 13,6%-ийг эзэлж байна. 2009 онд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 65 өргөдөл ирснээс 10 өргөдөлд дэмжсэн хариу, 55 өргөдөлд татгалзсан хариуг өгч Ашигт малтмалын газарт хүргүүлэн ажилласан.	10
3.	Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ. <b>“Ус” үндэсний хөтөлбөр</b> хэрэгжүүлнэ 6.0	2009 онд улсын төвсийн хөрөнгө оруулалтаар бэлчээр усжуулах арга хэмжээнд зориулж 80 сая төгрөгөөр 5 суманд 6 худаг, ХЯБХ-ийн хөрөнгөөр 5 худаг, малчид өөрсдийн хүчээр 2 худаг, Хэрлэнбаян-Улааны отрын нөөц нутагт 2 худаг, нийт 16 худаг шинээр гаргаж 45,5 мянган га бэлчээрийг усжуулсан байна. Малчид иргэдийн оролцоотойгоор нийт 38 энгийн уурхайн худаг гаргаж 76,0 мянган га бэлчээрийг нэмж усжуулсан байна.	30
4.	Ойн нөөцийг тогтвортой ашиглаж, ой хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрийг хадгалах нөхцөлийг хангана 6.0	2009 онд улсын төсвийн хөрөнгөөр 277 га талбайд ойжуулалт, 100га-д байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг хийж улсын комисст 75,8%-ийн амьдралттайгаар хүлээлгэн өгсөн байна. Уг ажилд нийт 49.5 сая төгрөг зарцуулагдаад байна.	30
5.	Амьтан, ургамлын аймгийн	2009 онд ахуйн зориулалтаар агнах, барих ан, амьтаны дээд хязгаарыг аймгийн	10

	нөөцийн хомсдолыг хязгаарлаж, тэдгээрийг байгалийн жамаар нөхөн сэргэх, тогтвортой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ 6.0	ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009.03.06-ны өдрийн 18 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан. Цагаан зээр-155 толгой, Бор гөрөөс 20 толгой, Загас 150, 2009 оны 6-8 сард тарваганы тоо толгой, тархалт, биологи, экологийн судалгааг хийх зорилгоор тодорхой тооны тарвагыг агнасан. Дэлгэрхаан суманд тусгай зориулалтаар гадаадын жуулчдад 2 аргаль агнуулж зөвшөөрлийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.	
6.	Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтөд дасан зохицож, сөрөг үр дагаврыг бууруулах чадавхийг бүрдүүлж хэрэгжүүлнэ 6.0	Аймгийн хэмжээнд бэлчээрийн даац, элсний нүүлт, цөлжилтийн төлөв байдлын тойм судалгааг хийх аргачлалыг боловсруулан баталгаажуулж сумдад хүргүүлэн судалгаа хийж үнэлгээ дүгнэлт гарган Галшар, Дархан сумдыг цөлөрхөг бүсэд хамруулах саналыг БОЯ, "Цөлжилтийн үндэсний хөтөлбөр"-ийн газарт, энэ бүс нутагт бэлчээрийн усан хангамж болон усжуулалтыг бодлогоор дэмжлэг үзүүлэх саналыг Усны хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлж "Цөлжилтийн үндэсний хөтөлбөр"-ийн газраас төсөл ирүүлэх саналыг хүлээн аваад байна. Хэрлэн голын орчмын доройтсон 14000га газрыг орон нутгийн хамгаалалтад авч 1га талбайд 2500 мод, бутыг шинээр тарилаа. Үлийн цагаан оготно тархсан нөхөн сэргээх шаардлагатай талхлагдаж доройтсон бэлчээр 101 мянган га байна гэсэн судалгаа гарсан ба энэ онд Галшар, Баянмөнх, Дархан, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Хэрлэн сумдын 30 мянган га бэлчээрт 46 сая төгрөгийн санхүүжилтээр устгалын ажил хийгдээд байна.	10
<b>2.0. Үйлдвэрлэлийн салбар</b>			
7.	Стратегийн орд газруудыг ашиглана. Улсын зардлаар геологийн хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон стратегийн орд газруудад төрийн мэдлийн хувийг 51-ээс дээш байлгах бодлогыг баримтална 5.2.1.1	Стратегийн орд газар байхгүй тул биелэлт гарах боломжгүй.	-
8.	Уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хадгална 5.2.1.1	Уул уурхайн үйлдвэрлэл эрхэлж байгаа "Баян-Эрдэс"ХХК, "Бэрх уул"ХХК, "Бор-Өндөрийн" УБҮ-ийн үйл ажиллагаанд хамтарсан шалгалт хийж, "Бор-Өндөрийн" УБҮ-ийн 2009 онд олборлолтонд өртсөн 1 га, Техникийн нөхөн сэргээлт 1га, Биологийн нөхөн сэргээлт 0.5 га нөхөн сэргээлт хийсэн. 2009 оны нөхөн сэргээлтийн тайланд дүгнэлт гаргасан. Баян-Эрдэс ХХК 2009 оны Байгаль хамгаалах төлөвлөгөөнд 20 га талбайд нөхөн сэргээлт хийх ажил хийгдээгүй байна, Бэрх уул ХХК Байгаль хамгаалах төлөвлөгөөнд 17 га нөхөн сэргээлт хийхээс 20 га талбайд нөхөн сэргээлт хийсэн.	30
9.	Стратегийн орд газруудыг ашиглах ажлыг эрчимжүүлнэ. Уул уурхай, ашигт малтмалын салбарт тэргүүний техник, технологийг эрчимтэй нэвтрүүлж, эцсийн	"Бичил уурхайг хөгжүүлэх" хөтөлбөрийн хүрээнд гар аргаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулах журам дэд хөтөлбөрийг бүх сумд, төрийн бусад байгууллагуудад хүргүүлж 5 суманд хууль бусаар гар аргаар алт, жонш, вольфром, цагаан тугалгыг олборлож байсан иргэдийг таслан зогсоох үйл ажиллагааг холбогдох байгууллагын ажилтнуудтай хамтран зохион байгуулсан. Цагдаагийн	30

	бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлнэ 5.2.1.1	газрын Эдийн засгийн албанаас хууль бусаар жонш олборлосон 2 иргэнийг эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр МБТ-д шилжүүлж, ашигт малтмалын тухай хуулийн дагуу зөрчил гаргасан 2 иргэнийг 1100.0 төгрөгөөр торгуулж, 12 тн орчим жоншийг хуулийн дагуу хурааж улсын орлого болгуулан, орон нутгийн төсвийн орлогод 3.2 сая төгрөг оруулав. Бор-Өндөр хотын Төмөр зам, Гаалиар ачигдаж гадагшаа экспортонд гаргаж байгаа 7000 орчим тн жонш, 4.000 орчим тн төмрийн хүдрийн гаалийн бүрдүүлэлт, татвар төлөлтийн байдалд хяналт тавьж ажиллаж байна. Дэд хөтөлбөрийн дагуу 2 суманд 5 нөхөрлөл байгуулагдан хууль журмын дагуу үйл ажиллагаа явуулж байна.	
10.	Гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ 5.2.1.2	"Хэнтий сүү" хоршоо нь ариун цэврийн шаардлага бүрэн хангасан 14 хоногийн хадгалах хугацаатай сүү, сүүн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж байна. Хэрлэн суманд "Мах экспорт" ХХК-ний салбар махны анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр 2009 оны 8-р сараас үйл ажиллагаа нь эхлэн 3 сарын хугацаанд 250 гаруй тн мах боловсруулаад байна.	30
11.	Бүс нутгуудын хөгжлийн дотоод, гадаад нөөц боломжтой оновчтой уялдуулан үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж хөгжүүлнэ 5.2.1.2	Хэнтий аймаг 2009 онд малын тоо 2251074 толгойд хүрч 320618 ширхэг арьс, шир, нэхий түүхий эд бэлтгээд байна. Үүний 60.4% буюу 193810 ширхэг хонины нэхий, 27.9% буюу 89535 ширхэг ямааны арьс, 6.2% буюу 20114 ширхэг үхрийн шир, 5.3% буюу 16658 ширхэг адууны шир, 0.2% буюу 501 ширхэг тэмээний шир эзэлж байгаа бөгөөд 810 тн ноос бэлтгэн зах зээлд нийлүүлсэн байна	30
12.	Оюуны шингэц бүхий, өндөр технологт суурилсан үйлдвэрлэлийн эзлэх байр суурийг бэхжүүлж, өсгөнө 5.2.1.2	Манай аймгийн хувьд одоохондоо ийм үйлдвэрлэл байхгүй	-
13.	Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ 5.2.1.3	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Бизнес эрхлэгчдийн аймгийн зөвлөгөөн"-ийг 2009 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Өндөрхаан хотноо зохион байгуулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн, "FPM" ХХК-ниас болон орон нутгийн бизнес эрхлэгчид 192 төлөөлөгч оролцож аймгийн хэмжээнд бизнес эрхлэхэд төр засгийн дэмжлэг оролцоо, хүндрэл бэрхшээлийн талаар зөвлөлдлөө. Уг зөвлөгөөнтэй холбогдуулан БНХАУ-ын ӨМӨЗОрны "Хөлөнбуйр хотын өдрүүд" үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан.	30
14.	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгоно 5.2.1.3	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан-д 773.5 сая төгрөгийг төвлөрүүлэн, салбар комиссыг байгуулан зээл олгох ажлын чиглэл, хэмжээ, бүрдүүлэх материалын талаар олон нийтэд цацаж, төсөл хэрхэн боловсруулах сургалтыг 2 удаа зохион байгуулж, төсөл хэрхэн боловсруулах зөвлөмж, загвар төслүүд зэрэг гарын авлага материалыг тарааж зөвлөгөө өгч ажиллаа. Үүний дүнд 131 иргэн, аж ахуй нэгжүүдээс 2 тэрбум 600 гаруй сая төгрөгний санхүүжилт хүссэн төсөл хүлээн авч салбар комиссын хурлаар хэлэлцэж шалгаруулан 58 төсөлд 773,5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгоод байна.	30

		<p>Зээлд хамрагдсан иргэд, аж ахуй нэгжүүдийг салбараар нь ангилж үзвэл Хөдөө аж ахуйн чиглэлээр 21 төсөлд 208 сая төгрөг, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 8 төсөлд 119,5 сая төгрөг, барилгын материалын үйлдвэрлэлд 4 төсөлд 101 сая төгрөг, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр 10 төсөлд 136 сая төгрөг, ахуй үйлчилгээний чиглэлээр 13 төсөлд 135,9 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлийг тус тус олгоод байна.</p> <p>Үүний дүнд орон нутагт 2009 онд шинээр 10 үйлдвэр бий болж, 174 хүний ажлын байр үүсэж жилдээ 900 гаруй сая төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл боломж бий болж байна.</p>	
15.	Үйлчилгээний зарим үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлж, эдийн засагт эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлнэ 5.2.1.3	<p>Дадал суманд 5 бүл зөгийний аж ахуй байгуулагдан энэ жил 35 кг бал аваад байна. Дэлхийн Зөн ОУБ-аас Дадал, Биндэр суманд зөгий үржүүлэх нөөц боломжтой газарзүй, цаг уурын нөхцөлтэй тул 50 бүл зөгийг нутагшуулан үржүүлэх ажлыг 2010 оноос эхлэн зохион байгуулахаар төлөвлөн Дадал, Биндэр сумдаас 15 хүнийг Сэлэнгэ аймгийн Шаамарт зохион байгуулагдсан "Зөгийг үржүүлэх, арчлах" сэдэвт сургалтанд хамруулсан. Мөн 100 бүл зөгий хадгалах зоорийг Биндэр сумаас хойш 15 км Зүүн мухар гэдэг газар 2.0 сая төгрөгөөр барьсан.</p>	30
16.	Бүс нутгийн онцлогыг харгалзан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, халдварт өвчний гаралт, тархалтыг эрс бууруулан малыг эрүүлжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, экспортыг нэмэгдүүлнэ 5.2.1.4	<p>Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 2004 оны 04 сарын 15-ны өдрийн аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж загвар аж ахуй байгуулах сумд, аж ахуйн газар, нутгийг тогтоож шийдвэрлэсэн билээ. Тус аймгийн Баян-Адарга суманд саалийн үхрийн, үхрийн бордооны аж ахуй, Дадал суманд зөгийн аж ахуй, Хэрлэн сумын 2-р багт үхрийн болон шувууны аж ахуй, мах-ноосны чиглэлийн хонины аж ахуй, Мөрөн суманд сүүний үхрийн эрчимжсэн аж ахуй эрхлэхээр газар нутгийг шийдвэрлэсэн. Одоогийн байдлаар Хэрлэн суманд 24 үнээний зогсоол бүхий сүүний үхрийн болон тахианы аж ахуйг “Хэнтий сүү” нэртэйгээр байгуулан үйл ажиллагаа явуулж байна. “Хэнтий сүү” хоршоо зайрмагны цех, сүү хөргөж ариутгах, савлах жижиг цех ажиллуулан аймгийн иргэд хөдөлмөрчдийг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангаж байгаа юм. Мөн Хэрлэн сумын 3-р багийн нутагт иргэн Л. Гансүх “Ундрах бүл” нэртэй бүл байгуулан зайрмаг, тарга үйлдвэрлэж савлан худалдаанд гаргаж байна. Хэрлэн суманд 8-р баг буюу Тахилгат тосгоны нутаг дэвсгэрт аймгийн Цөм сүргийн үржлийн төвд мах-ноосны чиглэлийн Тал нутгийн цагаан үүлдрийн хонь цэврээр үржүүлэгдэж байна. 2008 онд ХХААЯам, Францын хүнсний тусламжийн хамтарсан хороотой хамтран зарласан төслийн сонгон шалгаруулалтанд манай аймгаас 3 төсөл шалгаран нийт 22 сая төгрөгийн зээл олгогдон Баян-Адарга суманд гахайн аж ахуйн, Өмнөдэлгэр суманд махны үхрийн үржлийн аж ахуй эрхлээд байна. Түүнчлэн жил бүр эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр төсөл хөтөлбөрт иргэдийг хамруулан улмаар үйл ажиллагаа явуулж эхлээд байгаа иргэн, аж ахуй нэгжүүдийн тоо нэмэгдэж байна. Мөн 2009 онд Халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 6 нэр төрлийн/боом, галзуу, бруцеллёз, цусан халдвар, дотрын халдварт хордлого, хонь, ямааны цэцэг/</p>	10

		<p>тарилгыг 2121.7 мян.толгой малд тарих төлөвлөгөөтэйгээс 2102.8 мян.малд вакцинжуулалт хийгдэж төлөвлөгөө 99.1%-н биелэлттэй байна.</p> <p>Шувууны томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг 2 сумын 6 багийн 1577 шувуунд тарьсан болно.</p> <p>Паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх даалгавар, санхүүжилт байхгүй ч мал эмнэлгийн аж ахуй нэгжүүд өөрсдийн хөрөнгө хүчээр туулгалтанд 398.7 мянган мал, угаалганд 330.0 мянган мал, боловсруулалтанд 141.7 мянган мал, нийт 871.1 мянган малыг паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулсан.</p>	
17.	Газар ашиглалтыг сайжруулж, - усалгаатай тариаланг хөгжүүлэн, биотехнологи нэвтрүүлэн газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ 5.2.1.4	<p>“Атрын гурав дахь аян”-ны зорилтын хүрээнд 2 суманд нийт 12300 га атаршсан тариалангийн талбайг дуудлага худалдаагаар эзэмшүүлэн эргэлтэнд оруулсан байна.</p> <p>Энэ онд аймаг 13600 га-д уриншийн боловсруулалт хийхээр төлөвлөгөөтэй ажиллаж байгаа ба аж ахуйн нэгж, иргэд 15000 га-д хүргэж уриншийн боловсруулалт хийж дараа оны тариалалтандаа бэлтгэх төлөвлөгөөтэй ажилласнаас 2010 онд 10300 га-талбайд тариалалт хийхээр уриншийн боловсруулалт хийж бэлтгээд байна.</p> <p>Нийт 7660 га-д үүнээс улаанбуудай 6420 га, рапс 240 га-д тус тус тариалж улаанбуудай 10300 тн буюу нэгжээс 13.9 цн, төмс 382.2 га-д тариалж 4614 тн буюу нэгжээс 120.7 цн, хүнсний ногоо 180.1 га-д тариалж 2574 тн буюу 143 цн ургац тус тус хураан авсан. Төлөвлөгөөний биелэлт 99.2 хувьтай байна. 2010 онд тариалалтын хэмжээг өмнөх оноос 2633га-аар нэмэгдүүлэн шаардагдах үрийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 100тн улаан буудайн үрийг нөөцөлж аваад байна. 2009 онд улсын төвсийн хөрөнгөөр болон өөрийн хөрөнгөөр Дэлгэрхаан суманд 200га, Хэрлэн суманд 100га, Цэнхэрмандал суманд 10га, Бор-Өндөр хотын Захирагчийн ажлын алба 29,4га нийт 339,4 га талбайд 1493,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр услалтын систем шинээр барьж ашиглалтанд оруулсан.</p>	30
18.	Хүнсний үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулна 5.2.1.4	<p>“Сүү” үндэсний хөтөлбөрийн хүрээнд ХХААХҮЯамны “Сүү” төслөөс “Хэнтий сүү” хоршоо болон Дадал сумын иргэн н. Даваасамбуу нарт 5.9 сая төгрөгийн үнэ бүхий сүүг халааж ариутгах, хөргөх, савлах зэрэг иж бүрэн тоног төхөөрөмжийг 2 жилийн хугацаатай хүүгүй зээлээр олгоод байна. Тус аж ахуйн нэгж ариун цэврийн шаардлага бүрэн хангасан 14 хоногийн хадгалах хугацаатай сүү, сүүн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж байна. Батширээт суманд 10 тн сүү худалдан авч боловсруулах хүчин чадалтай “Сүү” ХК-ний салбар сүү боловсруулах цех, Биндэр суманд иргэн Б.Баатар хоногт 1 тн сүү худалдан авч боловсруулах цехийг ашиглалтанд оруулан үйл ажиллагаагаа явуулж байна. Батширээт сумын “Гурван нэртэй” хоршоо нь монгол үнээний сүүгээр импортыг орлох бүтээгдэхүүн болох Словак технологийн бяслагийг үйлдвэрлэн зах зээлд борлуулж байна.</p>	30
19.	Газар тариалангийн болон бэлчээрийн усан хангамжийг	Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах чиглэлээр ЭМСХ-2 төслийн санхүүжилтээр 4 сумын эмнэлэгт тус бүр 12.5 сая төгрөгийн өртөгтэйгээр	10

	сайжруулж, хөдөөгийн хүн амын ундны усны хэрэгцээ, шаардлагад тохирсон усны нөөцийг нэмэгдүүлнэ 5.2.1.4	гүний худаг ашиглалтанд орсон. ДЭМБ-ын хөрөнгө оруулалтаар Цэнхэрмандал сумын эмнэлгийг гүний худагтай болгож цэвэр бохир усны холболтыг хийж эрүүл ахуйн шаардлага хангасан орчинг бүрдүүлсэн. Мөрөн сумын 1 худагт усны хатуулгыг зөөлрүүлэх төхөөрөмжийг тавьж өгсөн. ДЗОУБайгууллагатай хамтран 3 суманд шинээр гүний худаг гарган тохижуулсан, 3 суманд 3 худгыг засаж сайжруулсан.	
20.	Малын тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, тэжээлийн шимт чанар, тэжээллэг байдлыг сайжруулах, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ 5.2.1.4	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 48 дугаар тогтоолоор “Малын тэжээл аймгийн дэд хөтөлбөрийг батласан. Түүнчлэн хөтөлбөрийн эхлэлийн семинар болон ХХААХҮЯам, ХААИС-тай хамтран зохион байгуулсан сургалтанд холбогдох албан тушаалтнуудыг хамруулан мэдээллийг тухай бүр сумдад өгч ажилласан болно. Мөн шимт чанар сайтай тэжээлийн ургамлыг хадаж өвс, өвсөн дарш, гар тэжээл бэлтгэх гарын авлагыг 17 сум 5 тосгонд тараасан. 2009 онд аймгийн хэмжээгээр 91218,7 тонн байгалийн хадлан хураан авч, малчин өрх, аж ахуйн нэгжүүд өөрсдийн нөөц боломжийг ашиглан 104,1 тонн гар, 35.7 тонн үйлдвэрийн тэжээл, 208.5 тонн ногоон тэжээл бэлтгэсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2009 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 182 дугаар тушаалаар батлагдсан “Хадлан тэжээл-2009 “уралдааны болзлыг аймгийн бүх сум, тосгодод хүргүүлж, хадлан тэжээл бэлтгэх ажилд малчид, иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд идэвх санаачлагатай оролцлоо.	10
21.	Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг хадгалах, чийгийн ууршилтыг багасгахад чиглэсэн дэвшилтэт технологийг газар тариаланд нэвтрүүлнэ 5.2.1.4	Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэдэг 17 аж ахуйн нэгжүүд хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах зорилгоор цомотгосон технологи буюу тэг элдэншүүлэгт боловсруулалт хийж уриншийг бэлтгэж байна. Хөрсийг эргүүлэхгүйгээр хаван сийрүүлэх боловсруулалтыг нийт аж ахуйн нэгжүүд хийж хэвшиж байгаа. 2010 онд 10300га-д үр тариа тариалахаар уриншийн боловсруулалтыг хийж бэлтгээд байна. 2009 онд ХХААХҮЯаманд газар тариалангийн техникийн парк шинэчлэлт хийгдэхэд шаардлагатай техникийн захиалгыг өгч ажилласнаар 170 м/хүчтэй трактор 3, 120 м/хүчтэй трактор 1, Т-150К- 3, хор цацагч 3, будаа цэвэрлэгч 1, ачигч 1, үрлэгч 3, дунд оврын трактор 3-ыг хөнгөлөлттэй үнээр олгоод байна.	30
22.	Биотехнологийг нэвтрүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулан, тарималын ургацыг нэмэгдүүлнэ 5.2.1.4	Тал нутгийн цагаан үүлдрийн хонины удмын санг хамгаалах, тоо толгойг олшруулах, үйл ажиллагааг тогтмолжуулах үүднээс ХХААХҮЯам, Улсын мал эмнэлэг үржлийн газар, Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран уг хонийг үржүүлж буй ЦСҮТөвд хяналт шалгалтыг зохион байгууллаа.Тоо толгой нь цөөрөөд байгаа мах-ноосны чиглэлийн ТНЦ үүлдрийн хонийг өсгөх, уг хонийг үржүүлж байсан Баянхутаг, Хэрлэн, Дадал сумдаас буцсан хонийг худалдан авч эрлийзүүлгийн ажлыг зохион байгуулах, нарийн ноост цэвэр үүлдрийн хээлтүүлэгчээр сайжруулах, дээрх сумдад зохиомол хээлтүүлгийн суурин болон явуулын цэгийг байгуулан ажиллуулах зэргээр шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн шийдвэрийг гаргаад байна. Дархан –Уул аймгаас Орхон үүлдрийн нарийн ноост 8 толгой хуцыг сайжруулагчаар авчирч үржилд ашиглаж байгаа бөгөөд 1-р үеийн эрлийзээс өсвөр хээлтүүлэгч бойжуулах ажлыг зохион байгуулж байна. Мөн Хэрлэн суманд Хэнтий	10

		<p>сүү хоршоо, ЦСҮТөв тус бүр зохиомол хээлтүүлгийн байнгын цэг, ХЯБХөтөлбөрийн дэмжлэгээр Биндэр суманд 2 явуулын цэг, Өмнөдэлгэр суманд ХЯБХөтөлбөрийн хөрөнгөөр, Батширээт суманд ХЯБХНэгжээс 6.0 сая төгрөгийн дэмжлэг авч байнгын цэг тус тус шинээр байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.</p>	
23.	<p>Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээний бүх хүрээнд эрүүл ахуй, ариун цэврийн зохистой орчин бүрдүүлж, хүн амыг аюулгүй, хүрэлцээтэй хүнс тэжээлээр хангана 5.2.1.4</p>	<p>"Хүнсний баталгаат байдал" үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан Аймгийн "Хүнсний баталгаат байдал" дэд хөтөлбөрийг боловсруулан засаг даргын зөвлөлийн 2009 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2009 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 97 дугаар тогтоолоор батлуулаад байна. Аймгийн хэмжээнд хүнсний бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээ эрхэлдэг 402 цэг байгаагаас согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа үйлчилгээ эрхэлж буй 220 аж ахуйн нэгжийн 273 цэг салбар үйл ажиллагаа явуулж байна. Хэрлэн суманд "Худалдааны газар, түүний үйлчилгээ ЕШ" MNS 5021:2007 улсын стандартын хэрэгжилтийн байдалд шалгалт хийхэд шалгалтанд хамрагдсан 59 хүнсний дэлгүүрүүдээс 6 хүнсний дэлгүүр 90-100 хувь буюу шаардлага бүрэн хангасан, 25 хүнсний дэлгүүр 80-89 хувь буюу шаардлага харьцангуй хангасан, 19 хүнсний дэлгүүр 65-79 хувь буюу шаардлага хангаагүй, 9 хүнсний дэлгүүр 64 хувиасдоош буюу хангалтгүй дүгнэгдлээ.</p> <p>Худалдаалагдаж буй хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын горим, чанар аюулгүй байдал, хүнсний сав баглаа боодолд шалгалт хийхэд 19 аж ахуйн нэгж, 2 ХХЭ иргэний нийт 449.48 мянган төгрөгийн хадгалалтын хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүнийг устгуулав.</p> <p>"Хоолны газарын ангилал зэрэглэл, үндсэн шаардлага MNS 4946:2005 улсын стандартын хэрэгжилтийн байдалд шалгалт хийхэд шалгалтанд хамрагдсан 16 баарнаас 5 баар 80-89 хувь буюу шаардлага харьцангуй хангасан, 5 баар 65-79 хувь буюу шаардлага хангаагүй, 6 баар 64 хувиас доош буюу хангалтгүй дүгнэгдлээ. Шалгалтанд хамрагдсан баарнуудын 11 нь буюу 68.7 хувь нь цэвэр бохир усны нэгдсэн системд холбогдсон, 5 баар холбогдоогүй байна.</p> <p>Өмнөдэлгэр сумын Ашид-Өрнөх ХХК, Ноён жаргалант ЗБН, ХХЭ Алтангэрэл, Биндэр сумын Хөгжил бүлэг, Дадал сумын Дэвших бүлгийн талхны цехүүд шалгалтанд хамрагдлаа. Шалгалтанд хамрагдсан талхны цехүүд 1-2 ажиллагсадтай, ажиллагсад эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдсан байна. Бэлэн бүтээгдэхүүнээ лабораторийн шинжилгээнд хамруулж улсын байцаагчийн дүгнэлт гаргуулаагүй, ажлын байр нь бохир, цэвэр ус, халаалтын системд холбогдоогүй, талх үйлдвэрлэх технологийн заавар, жор орцын норм боловсруулаагүй, халуун боловсруулалтын хэсэгт уур хуримтлуулах агааржуулах төхөөрөмж суурилуулаагүй, хаяг шошго стандартын шаардлага хангаагүй, зэрэг нийтлэг зөрчлүүд илэрч байна. Дээрх зөрчлүүдийг арилгах талаар талх үйлдвэрлэгч нарт болон сумдын удирдлага нарт гэрээрээ талх үйлдвэрлэж байгаа хүмүүсийг ажлын байртай болоход дэмжлэг туслалцаа үзүүлэх, цаашид гэртээ талх үйлдвэрлэж нийтийн хэрэгцээнд нийлүүлдэг байдлыг таслан зогсоох талаар анхаарч ажиллахыг зөвлөлөө.</p>	30

### 3.0. Дэд бүтцийн салбар

#### 3.1. Эрчим хүч

24.	Монгол Улсын “Эрчим хүчний нэгдсэн систем”-ийг байгуулж, эрчим хүчний салбарын ашигт ажиллагааны түвшинг дээшлүүлэн, хөгжлийн нэн таатай орчинг бий болгоно. Эрчим хүчний салбарыг эрчим хүч экспортолдог чадамжтай болгоно 5.3.2	"Эрчим хүчний нэгдсэн сүлжээ" хөтөлбөрт тусгагдсан Төвийн бүсийн эрчим хүчний сүлжээг Зүүн бүсийн эрчим хүчний сүлжээтэй холбох ажлын хүрээнд Өндөрхаан-Баруун-Уртын 240 км 110 квт-ын ЦДАШ-ын ажил дуусч эрчим хүчний нэгдсэн сүлжээ үүсгэлээ. Аймгийн бүх сумд эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдоод байна. Мөн Түлш, эрчим хүчний яам, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хэрлэн сумын 8 дугаар баг Тахилгат тосгоны цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэхээр болсон. Зураг төсвийг эрчим хүчний зураг, төсвийн Мон цахир ХХК, кадастрын зураглалыг аймгийн ГХБХБГазартай хамтран хийж байна.	30
25.	Сум, суурин газрын болон малчдын цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулна 5.3.2	2009 оны жилийн эцсийн тоогоор 6824 малчин өрхтэй бөгөөд үүнээс ямар нэгэн цахилгааны эх үүсгүүртэй 4068 өрх байна. 100000 нарны гэр үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын Засгийн газрын хөнгөлөлттэй үнээр 50 ваттын нарны зайн эх үүсгүүрийг Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвтэй хамтран 2003-2009 онд захиалгаар 1086 ширхэгийг малчин өрхөд түгээгээд байна. Мөн зах зээлээс иргэд 2224 ширхэг нарны цахилгаан үүсгүүр худалдан авсан бөгөөд нийтдээ 3292 малчин өрх нарны зайн үүсгүүрээс хангагдсан байна. 307 малчин өрх салхины эх үүсгүүр, 469 өрх бага оврын мотор болон бусад эх үүсгүүрээр хангагдсан байна. Эрчим хүчний газраас Дэлхийн банкны “Хөдөөгийн цахилгаан хангамжид сэргээгдэх эрчим хүчийг ашиглах” төслийн хүрээнд 2010 онд 20 000 малчин өрхийг НЦҮ-ээр хангах тендер зарлаж, зохих бэлтгэл хангаж байгаа бөгөөд манай аймгаас эхний ээлжинд 236 өрх НЦҮ захиалах судалгааг гаргаж хүргүүлээд байна.	30
26.	Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн үр ашгийг сайжруулж, хөгжлийн нэн таатай орчинг бий болгоно 5.3.2	Хэнтий аймаг эрчим хүчний нэгдсэн систэмийн хүрээнд Зүүн бүсийн эрчим хүчний систэмд давхар холбогдсноор эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбогдлоо	50
27.	Нүүрс хийжүүлж, бага оврын цахилгаан станцуудыг түлшээр хангана 5.3.3	“Шингэрүүлсэн шатдаг хий” хөтөлбөрийн хүрээнд манай аймагт 25-200 м3 багтаамжтай хий цэнэглэх станц байгуулахаар төлөвлөсөн бөгөөд уг ажил одоогоор эхлээгүй байна. Харин Өндөрхаан хотод Даншваанжил ХХК-ийн салбар шатдаг хийгээр иргэдэд үйлчлэх цэг байгуулагдаад байна. Тус цэг нь иргэдэд шатдаг хийн тоног төхөөрөмж худалдах, баллоныг цэнэглэж өгөх үйлчилгээг эрхэлж байна.	10
28.	Кокс-хими болон нүүрс, эрчим хүч, химийн үйлдвэрийн цогцолборыг байгуулж ажиллуулна 5.3.3	Манай аймгийн хувьд ийм үйлдвэрлэл байхгүй	-
29.	Нүүрсний цэвэр технологт тулгуурласан том хүчин чадлын цахилгаан станц барьж, нүүрснээс газрын тосны бүтээгдэхүүн гаргах үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн эзэмшинэ 5.3.3	Манай аймгийн хувьд ийм үйлдвэрлэл байхгүй	-



### 3.3. Барилга

30.	Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог хөгжүүлж, хот, суурингийн оршин суугчдад таатай орчин бүрдүүлнэ 5.3.5	Засгийн газрын 201-р тогтоолоор Зүүн бүсийн тулгуур төв "Өндөрхаан хотын ерөнхий төлөвлөгөө батлагдаж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Өндөрхаан хотын төвийн хэсгийн хэсэгчилсэн төлөвлөгөө хийлгэх зардлыг тооцож хөрөнгийн саналыг 2009 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар санал тавьсан боловч шийдэгдээгүй тул хөрөнгийн өөр эх үүсвэрийг судалж байна. Хотын оршин суугчдын таатай орчин бүрдүүлэх чиглэлээр 2009 онд 1.4 км хатуу хучилттай авто замыг 329.2 сая төгрөгөөр барьж замын дагуух цэцэрлэгжүүлэлт бүхий хашаа хайс, явган хүний замын тохижилтод 18.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулав. Мөн Өндөрхаан хотод 23.8 сая төгрөгийн өртөгтэй усан оргилуур барьж, нийтийн зориулалттай амралт тоглоомын талбай тохижуулахад 13.0 сая төгрөг зарцууллаа.	30
31.	Орчин үеийн чанарын шаардлага бүхий барилга, шинэ нэр төрлийн барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуйн салбарыг бий болгон хөгжүүлнэ 5.3.5	Өндөрхаан хотод "Ганцог" ХХК БНХАУлсад үйлдвэрлэсэн хоногт 50 000 шахмал тоосго үйлдвэрлэх хүчин чадалтай, автомат удирдлагатай иж бүрэн үйлдвэрийг оруулж ирэн үйлдвэрлэлээ эхлэн 2009 онд зах зээлийн эрэлтээс шалтгаалан 150 000 ширхэг тоосго үйлдвэрлээ. Энэ онд тус аж ахуйд Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 10.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олголоо. Даацын бус үнсэн болон пенобетон блок үйлдвэрлэхээр иргэдээс ирүүлсэн төслүүдээс 2 төслийг шалгаруулж хөнгөлттэй зээл олгов. Орон нутгийн нөөцөд түшиглэсэн тоосгоны болон, цементийн үйлдвэр барих хөрөнгийн асуудлыг ЗТБХБЯамнд тавьж сайдын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээнд тусгуулав. Нийтийн аж ахуйн салбарын үйл ажиллагааны хүрээнд 2007 оноос Өндөрхаан хотын "Хэнтий-Ус" ХХК-ны харъяа нэг болон хоёрдугаар уурын зуухнуудад ОНХНААХөгжүүлэх-2 үе шатны Мон-1907 төслийн хүрээнд "DZL" маркийн тогоо нийлүүлэх, суурилуулах ажил, гадна дулааны газар доорхи 3371 метр шугам болон Өндөрхаан хотын цэвэр усны 13125 метр шугамыг хуванцар хоолойгоор, бохир усны 3400 метр даралттай шугам, 3815 метр даралтгүй шугамыг хуванцар хойлойгоор бүрэн шинэчиллэх ажлыг "Хасу Мегаватт" ХХК гүйцэтгэснийг 2009 оны 3 сард Улсын техникийн комиссоор ашиглалтанд хүлээж авсан. Өндөрхаан хотын 3 дугаар багт ус түгээх цэг нэгийг барьж ашиглалтанд оруулсан бөгөөд уг ус түгээх цэгийн 350 метр цэвэр усны шугам угсралтын ажлыг Хэнтий-Ус ХХК хийж гүйцэтгэлээ.	30
32.	Хүн амын орон сууцны хангамжийг эрс сайжруулна. <b>"Орон сууц" үндэсний хөтөлбөр</b> хэрэгжүүлнэ 5.3.5	40000 айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд тус аймгийн хэмжээнд баригдах 200 айлын орон сууц барих дэд төсөл болосруулж хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу төлөвлөж газрын байршлыг тогтоон техникийн нөхцлийг олгон зураг төсөв нь хийгдсэн. 2009 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Өндөрхаан хотод 21, Бор-Өндөрхотод УБҮ-ийн хөрөнгөөр 21 айлын орон сууц баригдан тус тус ашиглалтад орж, 48 айлын орон сууцны барилга угсралтын ажил хийгдэж байна, 40 айл, 4 айлын 12 сууц баригдахаар гүйцэтгэгчийн тендер зарлагдаж 40 айлын орон сууцны барилгын ажил эхэлсэн. Нийтийн эзэмшлийн орон сууц барих хүсэлтэй аж ахуйн нэгжид төсөл сонгон шалгаруулалт болон дуудлага худалдаагаар олгох газрын	30

		төлөвлөгөөг гарган баталж газрыг олгож байна	
33.	Хот суурингийн газар ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгоно 5.3.5	ЗТБХБСайдын тушаалаар баталсан журмын дагуу барилга байгууламж бүрт хувийн хэрэг хөтлөх ажлыг 2009 онд шинээр баригдан ашиглалтад орсон барилгуудаас эхэлж 2010 онд бүх барилга байгууламжийг бүртгэх зорилгоор барилга байгууламж бүрт хөтлөх хувийн хэргийн дэвтрийг захиалаад байна. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш өссөн дүнгээр нийт 8515 өрх айл 1288.13 га газрыг үнэгүй газрыг өмчлүүлээд байна. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2009 оны 07 дугаар тогтоолоор үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар газрыг дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулалтаар олгох байршил, хэмжээг тогтоож өгсөн бөгөөд аймгийн хэмжээнд нийт 2904 м2 газрыг худалдаа үйлчилгээний зориулалтаар олгож 27.7 сая, үр тарианы зориулалтаар 12204 га газрыг олгож 60.1 сая нийт 87.8 сая төгрөгийг орон нутгийн төсөв оруулсан.	10
34.	Хот байгуулалтыг улам боловсронгуй болгож, барилгын шинэ нэр төрлийн бараа, хийцийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ 5.3.5	Хот байгуулалтыг боловсронгуй болгох түлхэц болохоор цементийн үйлдвэр барих техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж эхлээд байна. ШШГА-ны харъяа барилгын улаан тоосгоны үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинээр Ганцог ХХКомпани хоногт 50 000 ширхэг тоосго үйлдвэрлэх хүчин чадалтай өнгөлгөөний шахмал тоосгоны үйлдвэрлэж эхлэв. Мөн барилгын төмөр бетон эдэлхүүний үйлдвэр болон тоосго, цементийн үйлдвэр байгуулах хөрөнгийн асуудлыг тавьж ЗТБХБСайдын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээнд тусгуулаад байна.	30
<b>3.4. Тээвэр</b>			
35.	Зам, тээврийн салбарын хөгжлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгоно 5.3.1	Эрх зүйн орчинг яамны түвшинд боловсруулна.	-
36.	Авто замын сүлжээг өргөжүүлнэ 5.3.1	2004-2009 онд "Мянганы зам", Япон улсын Засгийн газрын "зүүн чиглэлийн гол авто зам барих, тоног төхөөрөмж нийлүүлэх" төслийн хүрээнд Хэрлэнгийн гүүр-Өндөрхааны чиглэлийн 165 км хатуу хучилттай автозам, Цэнхэрийн голын 60,7 метр төмөр бетон гүүр, Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн 50 км хатуу хучилттай автозам, Мөрөн-Өндөрхаан чиглэлийн 28 км хатуу хучилттай автозам, Хэрлэн голын 268.8 у/м төмөр бетон гүүрийг барьж ашиглалтанд оруулсан бол 2009 оноос Өндөрхаан-Сүмбэрийн дараагийн 50 км замыг үргэлжлүүлэн барьж байна. Уг замын ажилд 2009 онд 1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр трасс татах, газар шорооны ажлыг хийгдсэн. Өндөрхаан хот доторх автозамын сүлжээг өргөжүүлэх зорилгоор 1,4 км хатуу хучилттай зам ашиглалтанд оруулаад байна.	50
37.	Авто замын салбарт дэвшилтэд техник технологи нэвтрүүлж, авто зам, замын байгууламжийн чанарыг дээшлүүлж, ашиглалт, үйлчилгээг сайжруулна 5.3.1	Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Зүүн чиглэлийн гол автозам барих, тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн хүрээнд Хэнтий аймгийн зам засвар арчлалтын "Харгуй" ХХК-д 2 тэрбум гаруй төгрөгийн 19 төрлийн автозамын техник, асфальтбетон завод, чулуу бутлуурын заводыг буцалтгүй тусламжаар олгосон. Ингэснээр Харгуй ХХК-нь улсын чанартай 250 км хатуу хучилттай автозамын засвар	30

		арчлалт, ашиглалт, үйлчилгээг чанартай гүйцэтгэн хариуцан ажиллаж байна.	
38.	Төмөр замын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулна 5.3.1	Тус аймагт төмөр замын сүлжээ байхгүй.	-
39.	Агаарын тээврийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, дэд бүтцийг хөгжүүлэн, үйлчилгээг өргөжүүлж, агаарын тээврийг олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай, хувийн хэвшлийн оролцоо давамгайлсан салбар болгон хөгжүүлнэ 5.3.1	Агаарын тээврийн үйлчилгээ байхгүй.	-
40.	Далайн болон усан замын тээвэрт хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалт хийх таатай орчинг бүрдүүлж, үйл ажиллагааг нь өргөтгөнө 5.3.1	Далайн болон усан замын тээвэр байхгүй	-
41.	Улаанбаатар хотын авто замын сүлжээ, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулна 5.3.1	Аймагт хамааралгүй заалт	-
42.	Авто тээврийн хэрэгслээс хүрээлэн байгаа орчин, хүн ам, замын хөдөлгөөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг эрс бууруулна 5.3.1	2009 онд 5112 авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг үзлэг, оношлогоонд оруулснаас 3270-н тээврийн хэрэгсэл зөрчилтэй байсан бөгөөд үүнээс 1830 автомашиныг давтан үзлэг, оношлогоонд оруулж техникийн зөрчлийг арилгуулсан.	30
43.	Авто, төмөр замын сүлжээг өргөтгөн, агаарын болон усан замын тээврийг хөгжүүлж, аймаг, нийслэл болон бүсийн төвүүдийг хатуу хучилттай авто замаар бүрэн холбоно 5.3.1	Аймгийн төв Өндөрхаан хот, Мөрөн, Жаргалтхаан, Цэнхэрмандал сумд Улаанбаатар хоттой хатуу хучилттай автозамаар бүрэн холбогдсон. 2004-2009 онд Хэрлэнгийн гүүр-Өндөрхааны чиглэлийн 165 км, Мөрөн-Өндөрхаан чиглэлийн 28 км, Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн 50 км хатуу хучилттай автозам баригдаж ашиглалтанд орсон бол Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн дараагийн 50 км замыг үргэлжлүүлэн барьж байна.	50
<b>3.5. Мэдээлэл</b>			
44.	Мэдээлэл харилцааны технологийн салбарын программ хангамж, технологи, эрх зүй, бүтэц, зохион байгуулалт, санхүү, эдийн засгийн болон хүний нөөцийн нэн таатай орчинг бүрдүүлнэ 5.3.4	Эрх зүйн орчинг дээд байгууллагаас боловсруулна. Аймгаас биелэлт гарах боломжгүй.	-
45.	Мэдээлэл харилцааны технологийн ололтыг нийгэм,	2010 оны эхний хагас жилийн байдлаар манай аймгийн Өлзийт, Тахилгат тосгоноос бусад 17 сум, 2 хот, 2 тосгон нийт 21 сум суурин газарт үүрэн телефоны Mobicom,	30

	эдийн засгийн бүх салбарт өргөн нэвтрүүлнэ 5.3.4	Skytel, Unitel, G-Mobile, F-zone сүлжээ, давхардсан тоогоор 47 цэг ашиглалтанд ороод байна. Mobicom 14, Skytel 10, Unitel 7, G-Mobile 15, F-zone 1 суманд нэвтрээд байна. Энэ онд G-Mobile корпораци шинээр 5 суманд сүлжээгээ оруулахаар судалгаа, эдийн засгийн тооцоог гаргаснаар дээрх сүлжээ бүх суманд ашиглагдах боломжтой болох юм. 2008 оны жилийн эцэст үүрэн телефоны хэрэглэгч 11.5 мянга байсан бол 2009 онд 34.3 мянга болж өнгөрсөн оноос нэмэгдсэн байна.	
46.	Мэдээлэл, харилцааны технологийн салбарын программ-техник, мэдээлэл хангамж, технологи, бүтэц, зохион байгуулалт, санхүү, эдийн засаг, хүний нөөцийн болон эрх зүйн орчинг боловсронгуй болгож, шинэчлэн сайжруулна 5.3.4	Эрх зүйн орчинг дээд байгууллагаас боловсруулна. Аймгаас биелэлт гарах боломжгүй.	-
47.	Төрийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэтгэж, бодитой, үнэмшилтэй цахим мэдээллийн тогтолцоо, сан байгуулна 7.2	Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогоолоор батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи хэрэгжүүлэх нь үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2008 оны 12 сард аймгийн Архивын тасагт архивын баримтын тоо бүртгэл, эрэлт хайлтын ЕРМС программыг суулгуулсан. Уг программыг хэрэгжүүлэх явцад хөмрөгийн данс бүртгэлд зөрчил илэрч дахин данс бүртгэл шинэчлэх шаардлагын үүднээс тус программыг ашиглах асуудал одоогийн байдлаар зогсч данс бүртгэл шинэчлэх ажил эхлээд байна. Улсын бiртгэлийн ерөнхий хууль батлагдаж Иргэний бiртгэл, Хуулийн этгээдийн улсын бiртгэл, Эд херенгийн эрхийн бiртгэл нэгдэж /Онлайн/ сiлжээнд орсоноор мэдээллийн нэгдсэн сiлжээтэй болж Иргэний бiртгэлийн мэдээллийн санг 21 аймаг төдийгүй аймгийн төвийн сумдын хэмжээнд 8-терлийн бiртгэл, дотоод шилжилт хөдөлгөөн, иргэний iнэмлэхийн бiртгэл, гадаад паспортын бiртгэл, архивын лавлагаа гаргах, харах боломжоор хангагдаад байна	30
<b>3.5. Аялал жуулчлал</b>			
48.	Жуулчин тээвэрлэх болон жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлж, аялал жуулчлалын гол бүс нутгийн зам харилцаа, холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулна 5.2.1.5	Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн ИТХ-ын 2005 оны 72 дугаар тогтоолоор аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрөөр аялал жуулчлалын 3 маршрутыг баталсан бөгөөд уг маршрутын дагуу жуулчид ихээр ирж түүхийн болон соёлын үзвэр үзэж байна. 2008-2009 онд 16 жуулчны бааз тогтвортой үйл ажиллагаа явуулж давхардсан тоогоор 2000 гаруй жуулчин хүлээн авсан ба орон нутгийн төсөвт 60.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.	30
49.	Аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг барьж байгуулан, аялагч, жуулчдын сонирхлыг	Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төлөвлөгөөг шинэчлэх хөгжлийн цогц бодлого, төлөвлөгөөтэй/2009-2021/ уялдуулан 2009-2010 онд хэрэгжүүлэх богино хугацааны ажлын төлөвлөгөө гарган ажиллаж	30

	татсан аяллын төрлүүдийг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлнэ 5.2.1.5	байна. Мөн аялал жуулчлалын салбар хөрөнгө оруулагчдын олон улсын уулзалт зөвлөгөөнийг 2010 онд зохион байгуулагдахаар төлөвлөж, уг зөвлөгөөнөөр Дадал суманд аялал жуулчлалын томоохон цогцолбор, хөшөө байгуулах хөрөнгө оруулагч нарыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох зорилт тавьж байна	
50.	Аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлж, үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэж сайжруулна 5.2.1.5	Аймгийн 2009-2021 он хүртэл хөгжүүлэх цогц бодлого боловсруулан уг бодлогын баримт бичигт зүүн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тусгаад байна.	10
<b>4.0. Нийгмийн салбар</b>			
<b>4.1. Эрүүл мэнд</b>			
51.	Сум, өрхийн эмнэлгийн анхан шатны тусламж хүргэх, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ, дархлаажуулалт хийх, шүдний өвчин эмчлэх, бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол, сүрьеэгээс сэргийлэх, эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах чадамжийг цогц байдлаар хөгжүүлнэ 4.5	<p>2007, 2008 онд төгссөн дадлагажигч 28 эмчээс сумын эмнэлэгт 17, өрхийн эмнэлэгт 4 эмч хуваарилаж сум, өрхийн эмнэлэг их эмчээр бүрэн хангагдаж, анхан шатны тусламжийн хүртээмж чанар сайжирлаа. Жирэмсэн эхчүүдийн 83 хувийг мэргэжлийн эмчийн хяналтанд төрүүлж байна. 2009 оны байдлаар дархлаажуулалтын хамралт 99.2 хувьтай байна. Үүнд: БЦЖ 99.2, Тавт 100, Саа 100, УГУ 100, ВГВ 99,2 хувьтай байна. Дархлаажуулалтын 10 хоногоор 7,15 настай хүүхдүүдийг сахуу татрангийн 2-т вакцинд хамруулсан ба нөхөн дархлаажуулалтыг зохион байгуулав.</p> <p>ЭМЯ, ХӨСҮТ –тэй хамтран ВГВ-ийн дархлал тогтоцийн түвшинг үнэлэх судалгаанд 3 сумын 4-6 насны 250 хүүхдийг хамруулав. Томуугийн 780 хүн тун вакциныг эмнэлгийн болон мэргэжлийн хяналт, онцгой байдлын эмч мэргэжилтэн, ажилтан албан хаагчдад хийж мэдээг хүргүүлэв Мөн 5-т вакциныг нэвтрүүлж 448 хүүхдийг 100% хамруулсан байна.</p> <p>Сүрьеэгийн диспансерийн хяналтанд 129 тохиолдол илэрсэн. Үүнд идэвхитэй хэлбэрийн сүрьеэ - 47, дахилт 10, уушигны бусад хэлбэрийн сүрьеэ – 72 Нийт урьдчилан сэргийлэх үзлэг 6120 үзлэгийн хувь - 110 %. Сүрьеэгийн диспансер сумдын эмнэлгийн дарга нартай гэрээ байгуулан, 5 суманд сайн дурын идэвхитэнг ажиллуулж, цэрний шинжилгээг зөөвөрлөж, нийт 173 хүнийг хамруулж, уушигны идэвхитэй хэлбэрийн сүрьеэ 7-г илрүүлж, сорьц хадгалах бага оврын хөргөгч, цэр тээвэрлэх саваар хангалаа. Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгээс хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хоолтой эмчилгээнд 30 хүн хамруулж, 20 хүнд гэрээр эм хүргэлт хийсэн. ДЗОУБ, ЭМЯамнаас зарласан улсын уралдаанд 2-р байр эзэлж, ДЗОУБ-аас хийсэн хяналт үнэлгээнд хангалттай үнэлгээ авсан. ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн лабораторийн мэргэжилтэнг урьж нийт 34 хүнд лабораторийн сургалт хийсэн. Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт болон БЗДХ–с урьдчилан сэргийлэх эрсдэлтэй зан үйлийг өөрчлөх сургалт явуулсан. Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх үзлэг шинжилгээг эрсдэлтэй өртөж болох бүлгийн хүмүүсийн дунд хийсэн.</p> <p>СДЗШТөв нь 817 хүнд зөвлөгөө өгч, 2217 хүнд сургалт явуулсан. ДОХ/ХДХВ</p>	30

		<p>өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөрийн хүрээнд: ХДХВ/ДОХ -той тэмцэх дэлхийн өдрийг угтаж “Амьдар, амьдрахад нь тусал” уриан дор ДЗОУБ, ЭМГ, Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэс, Сан бүрд олон сувгийн телевизтэй хамтран зохион байгуулсан.</p> <p>ЭМЯ-ны 12/243 тоот тушаал “НҮЭМ болон БЗДХ-ын тусламж үйлчилгээний уялдаа холбоог сайжруулах замаар ХДХВ/ДОХ-ын халдварын эрсдэлийг бууруулах” төслийн хүрээнд БЗХ-аас урьдчилан сэргийлэх /тэмбүү, ХДХВ илрүүлэх/ шинжилгээг хяналтанд орсон 1636 жирэмсэнд 28-32 долоо хоногтойд хийсэн. ЭМГ-ын даргын 37 тоот тушаал гарч, төлөвлөгөөний дагуу өрх, сумдын эх баригч бага эмч нарт сургалт хийж өрхийн 10 эмч, НЭмнэлэг, сумын 30 эх баригч хамрагдсан</p>	
52.	Аймаг, дүүргийн болон улсын клиникийн нэгдсэн эмнэлэг, мэргэжлийн төвүүдийн үйл ажиллагааны чадамжийг хөгжүүлнэ 4.5	<p>Аймгийн нэгдсэн эмнэлэгийн бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн удирдлагын багийн сонгон шалгаруулалт явуулж, чанарын менежерийг бие даасан орон тоогоор ажиллуулав.НЭ-ийн өргөтгөлийн барилга ашиглалтанд орж хүлээн авах, эрчимт эмчилгээ, мэс заслын I,II, төрөх эмэгтэйчүүдийн тасгийг байршуулан эмч ажиллагсад, үйлчлүүлэгчдэд тав тухтай эрүүл мэндийн орчин нөхцлийг бүрдүүлсэн. Нэгдсэн эмнэлэгийн тасгууд дотоод сүлжээ, интернетээр холбогдож, сургалтын өрөө, хүлээн авахыг компьютероор бүрэн хангалаа. АНУ-ын Project CUKE хүмүүнлэгийн сангаас мэс заслын ор, 1 удаагийн хагалгааны материал, ДЗОУБ, Глобаль сангийн санхүүжилтээр Улаан тууз, хүүхэд, сүрьеэгийн тасгуудыг тохижуулж, рентген аппарат, флюор аппарат, гематологийн BC-2800 хагас автомат анализатор, биохимийн VIAUAL-маркийн анализатор, гал тогоо, угаалга, ариутгалын ком иж бүрдэл тоног төхөөрөмж, эмнэлгийн бус тоног төхөөрөмж ширээ сандал зэрэг нийт 1.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж тоног төхөөрөмжийн хангалт 80 %-д хүрлээ. Үйл ажиллагааны чадамж дээшлүүлэхийн тулд сувилахуйн алба нь 4 секторт хуваагдан эмчилгээний тасгуудыг палатны системийн зохион байгуулалтанд оруулж ажил амралтын цагийг хөдөлмөрийн хуульд нийцүүлэн ажилласан нь үр дүнгээ өгч байна.</p>	30
53.	Эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай боловсон хүчнээр хангана 4.5	<p>ЭМСалбарт 156 их эмч Эмч мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах тасралтгүй болон богино хэмжээний сургалтуудад хамруулан. 10 эмчийг мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтанд хамруулав. ЭМШУИС-ийн багш, мэргэжилтэнг урьж ирүүлэн орон нутагт эмнэл зүйн болон ёс зүй, харилцааны сургалтуудад давхардсан тоогоор 350 эмч мэргэжилтнүүдийг хамруулсан. Мөн ажлын байр солилцуулах, туршлага судлах үйл ажиллагааг зохион байгуулсан. Нэгдсэн эмнэлгийн их эмчийн хангалт 95 %-тай байна.</p>	30
54.	Хүн амын өвчлөл, цаг бусын нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг ахиулна. Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг	<p>НЭМ-ийн талаар төрөөс баримтлах бодлого, МУЗГ-ын үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗГ-ын 224 дүгээр тогтоолын сэдэвчилсэн төлөвлөгөөний дагуу иргэдэд ЭМБоловсрол олгох, эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлэх, дадал хэвшилд сургах чиглэлээр сар бүр нийтийг хамарсан төрөл бүрийн арга хэмжээ, үйл ажиллагаа зохион байгуулан</p>	30

	төлөвшүүлнэ 4.5	давхардсан тоогоор 62606 иргэдийг сургалт сурталчилгаанд хамруулав.	
55.	Эрүүл мэндийн салбарт удирдлага, санхүүжилтийн нэгдмэл тогтолцоог хөгжүүлнэ 4.5	2009 оны эхний хагас жилийн тайлан төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, эрхлэгч, нябо нарыг оролцуулан ЭМГазрын зөвлөлийн өргөтгөсөн хурал зохион байгуулсан. ЭМСайдын 2009 оны 74 тоот тушаалыг үндэслэн ЭМГазрын даргын 2009 оны 34 тоот тушаалаар ЭМБ-уудын нягтлан бодогч нарыг сэлгэн ажиллуулсан. Эрүүл мэндийн газрын дарга нь аймгийн Засаг даргатай 5.803.0 сая төгрөгийн санхүүжилттэйгээр үйл ажиллагаа явуулах өртөг бүхий 34 бүтээгдэхүүн нийлүүлэх “Менежерийн гэрээ”-г байгуулан хэрэгжүүлсэн ба “Менежерийн гэрээ”-ний биелэлт 89.6 хувьтай дүгнэгдсэн.	30
56.	Хүн амыг аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр ханган эрүүл мэндийн шаардлагатай, зохистой технологийг нэвтрүүлж, салбарын дэд бүтцийг сайжруулна 4.5	Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ЭМСайдын 2006 оны 03-р сарын 02-ны өдрийн 53 тоот тушаал “ЭЭСангийн ажиллах журам”-ыг үндэслэн ЭМГазар, сумын Засаг дарга, сумын эмнэлэг, ЭЭСангийн эрхлэгч нартай дөрвөлсөн гэрээ байгуулан ажиллаж байна. МУЗГ-ын 50 дугаар тогтоолын дагуу өрхийн эмнэлэг, ЭЭСангийн хөрөнгийг орон нутгийн өмчлөлд бүртгэх талаар Аймгийн ИТХТэргүүлэгчдийн тогтоол гаргуулсан. Хүн амыг аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах ажлын хүрээнд Нэгдсэн эмнэлэгт эмийн тендер зарлан эм ханган нийлүүлэх байгууллагуудаас эмийг тендерээр авч эмчилгээнд зарцуулав. НДХэлтэстэй сумын эмнэлгийн эрхлэгч гэрээ байгуулан ЭЭСангаар дамжуулан иргэдэд хөнгөлөлттэй жороор үйлчлэх асуудалд онцгой анхаарч ажилласнаар 2 сумаас бусдад нь энэ үйл ажиллагаа тогтмолжиж иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцэж байна. Эмч мэргэжилтнүүдэд “Эмийн зохистой хэрэглээ” сэдвээр сургалт явуулж 65 мэргэжилтнийг хамруулсан.	30
<b>4.2 Боловсрол</b>			
57.	Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ 4.4	2009 оны байдлаар аймгийн хэмжээнд байгаа нийт 6 настай 1361 хүүхдийн 922 буюу 67,7%-ийг цэцэрлэгт, 177 буюу 13%-ийг хувилбарт сургалтанд, нийт 1099 буюу 80,7%-ийг ЕБС-д бэлтгэж өгсөн. 2009-2010 оны хичээлийн жилд хамрагдвал зохих 2-5 насны нийт 5237 хүүхдээс 3022 буюу 57,7% нь цэцэрлэгийн үндсэн сургалтанд, 1090 буюу 20,8% нь хувилбарт сургалтанд, нийт 4112 хүүхэд буюу 78,5% нь хамрагдаж, БСШУ-ны сайдтай байгуулсан гэрээний зорилтоос 0,5 хувиар давуулан биелүүлсэн. Хэнтий аймгийн бүх сумдад Гэгээрэл төвийн үйл ажиллагаа тогтмолжсон ба сургууль завсардагчдаас гадна иргэдэд амьдрах ухааны болон бусад сургалтуудыг зохион байгуулж байна. Бичиг үсгийн боловсрол олгох сургалтанд нийт 307 хүн хамрагдсан бөгөөд үүний 25.4 хувь нь эмэгтэй. Бичиг үсэг үл мэдэгч 163 хүнийг бичиг үсэгтэй болгосон бөгөөд үүний 34.3 хувь нь эмэгтэй. Бичиг үсэг үл мэдэгчдийн нийт хүн амд эзлэх хувь 1.5. Сургалтыг АББ-ын багш нар удирдан зохион байгуулсан бөгөөд сургалтыг олон улсын төсөл /Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөр/ хөтөлбөрөөс гадна улсын төсвөөс санхүүжүүлсэн бөгөөд сургалтанд нийт 3.060.000 төгрөг зарцуулсан. Дүйцсэн сургалтын хөтөлбөрт хамрагдсан сурагчдаас	30

		<p>2007-2008 оны хичээлийн жилд 71 хүүхэд суурь боловсрол эзэмшсэн бол 2008-2009 оны хичээлийн жилд 117 хүүхэд суурь боловсрол эзэмшиж үүнээс 21 төгсөгч дараагийн шатны боловсрол эзэмших сургалтанд хамрагдаад байна.</p> <p>Хэнтий аймгийн төрийн өмчийн 25 ЕБ-ын сургуульд 7830 суралцагч, хувийн өмчийн 1 ЕБ-ын сургуульд 131 суралцагч нийтдээ бага ангийн 7961 суралцагч үдийн цай хөтөлбөрт хамрагдаж байна. Ерөнхий боловсролын 26 сургуулиас зориулалтын гал тогоотой сургууль 8 байгаа боловч үдийн цайнд хамрагддаг сурагчиддаа гал тогоогоороо үйлчлэх боломжтой үйл ажиллагаагаа явуулж байгаа сургууль 1 байна, 18 сургууль зориулалтын гал тогоо байхгүй, ЕБС-ийн гал тогоо тоног төхөөрөмж дутагдалтай байна. Аймгийн БСГ-аас 2009 онд ЕБ-ын сургуулиудын үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцаж үнэлгээ дүгнэлт гарган, холбогдох зөрчил дутагдлуудыг арилгах талаар зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэсэн. ЕБ-ын 26 сургуулийн үдийн цай хөтөлбөрийн үйл ажиллагаатай танилцаж, түүнийг хэрэгжүүлэх журмын дагуу үнэлгээ хийсэн бөгөөд аймгийн дундаж үнэлгээ 80.02%-тай дүгнэгдлээ. Төсөл хөтөлбөрийн хүрээнд Баянмөнх, Норовлин сумдын сургуулийн гал тогоо, Өмнөдэлгэр сумын сургуулийн дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмжид нийт 9,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.</p>	
58.	<p>Боловсролын бүх түвшний стандарт, сургалтын хөтөлбөрийг тухайн үеийн суралцагчийн хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно 4.4</p>	<p>Орон нутгийн хэмжээнд боловсруулах боломжгүй. БСШУЯ-наас боловсруулан гаргадаг.</p>	-
59.	<p>Багшийн мэргэжил, арга зүйн хөгжил болон цалин хөлс, урамшуулал, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, энэ чиглэлд хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлнэ 4.4</p>	<p>Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх нь багшийн хөгжлийн цаашилбал аймгийн боловсролын хөгжлийн тулгуур гэж үзэн хөрөнгө санхүүгийн бололцоогоо дайчлан БСШУЯ, МУБИС, олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж 6,5 сая төгрөг зарцуулж, улсын хэмжээний сургалтанд 130, бүсийн сургалтанд 852, аймаг, орон нутгийн хэмжээний сургалтанд давхардсан тоогоор 912 багшийг хамруулж, мэргэжил боловсролыг нь дээшлүүлээд байна. Мөн удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтанд 125 хүн хамрагдаад байна. Мэргэжил боловсролыг дээшлүүлэх сургалтанд хамруулахаас гадна жил бүр зохион байгуулдаг "Тэргүүний багш", "Бүтээлч багш" шалгаруулж, багш нарын бүтээлийн үзэсгэлэн гаргаж эцэг, эх, хөдөлмөрчдөд сурталчилсан. Үүнээс гадна багш бүр өөрсдийгөө хөгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж, компьютер, англи хэл, монгол бичиг, IQ болон өөрсдийн авъяас сонирхолын дагуу 90 гаруй багш мэдлэг чадвараа дээшлүүлсэн. Мөн Дорнод дээд сургуультай хамтран бакалаврын боловсрол олгох эчнээ сургалтанд 16 багшийг хамруулснаас гадна МУБИС-ийн</p>	30



		<p>Данийн Их сургуультай хамтран "OUTREACH" төслийн сургалтанд 12 сургуулийн 33 багш хамрагдсанаас 20 багш магистрын зэрэг хамгааллаа. 27 цэцэрлэг, 1 ясли, 26 сургуулийн багш сурган хүмүүжүүлэгч нарт 3 удаа мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Багш нарын мэргэжил боловсролыг дээшлүүлэхэд тохилог орчин чухал байдаг тул аймгийн төвийн 4 сургууль, сумдын 9 сургууль багшийг ажлын байрандаа хөгжих бололцоогоор хангаж, шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр, Боловсролын хөгжлийн хөтөлбөрөөс 26 сургуульд 6 настай хүүхдийн сандал, ширээ, сургалтын хэрэглэгдэхүүн, компьютер, дижитал аппарат, техник хэрэгслэлээр хангав. Мөн Боловсролын хөгжлийн хөтөлбөр, Азийн хөгжлийн банкнаас сумдын 3 сургуульд иж бүрэн электрон номын сан олгосон нь сурагч багш нарын сурч ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлж өглөө. Аймгийн төвийн 4 сургууль, сумдын 4 сургууль интернэтэд холбогдон цахим мэдээллийг ашигласнаар багш нар сүүлийн үеийн мэдээллийг олж авахаас гадна харилцан туршлага солилцох чухал алхам боллоо. БСГ, АЗДТГ, МХГ хамтран боловсролын салбарын 16 байгууллагад боловсролын талаар хууль тогтоомж, орчны стандартын хэрэгжилт, сурлагын чанар төсөл хөтөлбөрүүдийн явц, үр дүнг тооцон үнэлж дүгнэж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласнаар БСШУЯ-ны шагналаар 50, БСГ-ын шагналаар 72 багш, аймгийн Засаг даргын шагналаар 32 багш, удирдах ажилтныг шагнаж урамшууллаа. 2009 онд шинээр их, дээд сургууль төгссөн 22 багшийг бүртгэж 16-г нь ажлын байраар хангаж, СӨБ-ын багшийн хангалт 54%, ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалт 98,4% боллоо. Мөн улирлын үр дүнгийн гэрээний мөнгийг бүх сургуулиудад олгосноор үр бүтээлтэй ажилласан багш, удирдах ажилтнуудыг урамшуулах боломжтой болсноос гадна БТХ-ийн 43.1.6, 7дугаар зүйлд заасны дагуу 5 жил тутамд нэг удаа олгодог тэтгэмжийг 2009 онд нийт 79 багшид 9446,6 сая төгрөг олголоо. Аймгийн Засаг даргын санаачлагаар багшийн ажлыг бодитой үнэлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2010 оноос эхлэн жил бүр аймгийн "Тэргүүний багш" шалгаруулахаар болж, журмын төслийг хэлэлцэж байна. Мөн БСШУ-ны сайдын 2010 оны 21 дүгээр тушаалын дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын байгууллагуудын албан хаагчдыг орон сууцны зээлд хамруулах хуваарийн дагуу хуваарилалтыг хийж байна. Манай аймагт нийт 57 орон сууцны хуваарилалт ирсний дагуу саналыг авч байна.</p>	
60.	<p>Боловсролын тогтолцоог боловсронгуй болгох, чанарыг дээшлүүлэх замаар олон улсын жишигт ойртуулахад төрийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлнэ 4.4</p>	<p>2009 онд боловсролын салбарт улсын төсвийн болон ОУ-ын төсөл хөтөлбөрийн хүрээнд нийт 4,2 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж байгаас 721,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 6 сумын сургуулийн дотуур байрны барих, засварлахад зарцуулагдаж байна. Мөн ХБУ тосгоны сургуулийн дотуур байрны шинэ барилгыг ХЯБХ-ийн хүрээнд 135 сая төгрөгөөр барьж ашиглалтанд оруулаад байна. Аймгийн хэмжээнд сургуулийн дотуур байранд 1220 хүүхэд амьдарч байгаа бөгөөд энэ нь нийт дотуур байранд амьдрах шаардлагатай хүүхдийн 83,6 хувийг</p>	30

		эзэлж байгаа нь өнгөрсөн онтой харьцуулвал 2,5 хувиар нэмэгдсэн байна.	
61.	Иргэд боловсролоо сайжруулж, ажил мэргэжлээрээ хөрвөн суралцаж байх бодит боломж олгосон боловсролын нээлттэй агуулга, уян хатан арга хэлбэрийг бий болгож хэрэгжүүлнэ 4.4	Тус зорилтын хүрээнд аймгийн хэмжээнд ЕБС-ийн багшийн хангалт 98,4% СӨБ-ын багшийн хангалт 54%-тай байгаад дүн шинжилгээ хийн цэцэрлэгийн мэргэжлийн багшийн хангалтыг сайжруулахад голлон анхаарч, аймгийн Засаг даргын 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд уг асуудлыг тусган хэрэгжүүлж байна. 2008-2009 оны хичээлийн жилд УБ болон Дорнод ДС-д цэцэрлэгийн багшийн сургалтанд 11 багш, МУБИС-ийн СӨБ-ын багш бэлтгэх хөрвөх сургалтанд 6 багш, суралцаж байна. 2009-2010 оны хичээлийн жилд ч ЕБС-д илүүдэлтэй байгаа бага ангийн 10 багшийг МУБИС-аас шинээр зохион байгуулж байгаа мэргэжлээр хөрвөх сургалтанд сургахаар бүртгээд байна. Мөн төрийн байгууллагын албан хаагчдын мэдлэг ,мэргэжлийг дээшлүүлэхийн тулд сургалтын төлбөрийг орон нутгийн төсвөөс хариуцан жил бүр 5 хүнийг Удирдлагын академид сургаж байна. Мөн ХУИС-ийн магистрын сургалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, нийт 60-аад төрийн албан хаагч хамрагдаж байна.	30
62.	Сургууль төвтэй менежментийг хөгжүүлж, сургалтын байгууллагын бүтэц, хэв шинж, байршлын зураглалыг шинэчлэн зохионо 4.4	Орон нутгийн хэмжээнд гарах боломжгүй	-
63.	Зах зээлийн эрэлт хэрэгцээ шаардлагыг хангахуйц судалгаа, боловсруулалтын өрсөлдөх чадвартай хэвшлүүдийг бий болгож хөгжүүлнэ 4.7	Орон нутгийн хэмжээнд гарах боломжгүй	-
64.	Үндэсний инновац, бүтээмжийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлж, эдийн засаг, нийгмийн шинэчлэлд түүний оруулах хувь нэмрийг дээшлүүлнэ 4.7	Орон нутгийн хэмжээнд боловсруулах боломжгүй	-
65.	Судалгаа, боловсруулалтын ажлын үр дүнг хамгаалах, ашиглах эрх зүйн орчин, тогтолцоог боловсронгуй болгоно 4.7	Орон нутгийн хэмжээнд боловсруулах боломжгүй	-
66.	Шинжлэх ухаан, технологийн гадаад хамтын ажиллагааны үр ашгийг дээшлүүлнэ 4.7	Орон нутгийн хэмжээнд боловсруулах боломжгүй	-
<b>4.3. Соёл</b>			
67.	Үндэсний соёлыг эрчимтэй хөгжүүлэх эдийн засаг, зохион байгуулалтын тааламжтай орчинг	Үндэсний соёлыг эрчимтэй хөгжүүлэхэд анхаарч Монгол улсын Засгийн газраас батласан үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр, төлөвлөгөө гарган ажиллаж байна.	30

	<p>бүрдүүлнэ 4.6</p>	<p>Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг сэргээн засварлах хөтөлбөрийн хүрээнд 2010 онд Улсын хамгаалалтанд байгаа Сэцэн ханы ордны барилгыг цогцолбороор нь сэргээн засварлахаар болоод байна. Монгол улсын Засгийн газрын 175 дугаар тогтоолоор Улсын хамгаалалтанд байгаа 4 байгууламжийн хамгаалалтын бүс, солбилцлын цэг, координатыг тогтоолоо.</p> <p>Баян-Адарга сумын "Дуурлиг нарс"-ны Хүннүгийн булшинд хайгуул малтлага хийхээр зөвшөөрөл авсан Мон-Солонгос эрдэм шинжилгээний багийн гишүүд 8 сарын 25 ныг дуустал хугацаанд ажиллах гэрээ хийж тайланг сумын Засаг даргад тайлагнасан байна. Улсын хамгаалалтанд байдаг Баянхутаг сумын "Сэрвэн хаалганы бичиг"-ийн ойр орчмын булш хиргэсүүрийг ухсан байсныг илрүүлж, зохих арга хэмжээ авлаа.</p>	
<p>68.</p>	<p>Хүн амд соёл, урлагийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж, иргэдийн оюуны хэрэгцээг хангах талаар дорвитой ахиц гаргана 4.6</p>	<p>Хүн амд соёл урлагаар үйлчилгээг хүртсэн үйлчлүүлэгчдийн тоо өнгөрсөн оноос 71 хувиар өсч, соёлын салбарт 108.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. "Монгол бичиг" үндэсний хөтөлбөрийн зорилтыг үндэслэн боловсруулсан аймгийн дэд хөтөлбөрийг аймгийн Засаг даргын 39 тоот захирамжаар баталгаажуулж үндсэн 4 зорилтын хүрээнд боловсруулан ажиллаж байна. Нийт сургуулиудад хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд шалгуулагч сурагчдын тоо, мэдлэгийн түвшин, хичээл зааж буй багш нарын тоо өссөн бөгөөд 2008 онтой харьцуулахад 2009 онд шалгуулагчдын сурлагын амжилт 6,2%, чанар 16,7%, мэдлэг эзэмшилтийн түвшин 13,8%-иар ахисан байна.</p> <p>"Морин хуур" хөтөлбөрийн хүрээнд "Цэц Монгол" морин хуурын чуулга Аймгийн Засаг даргын дэмжлэгээр Хан Хэнтий хөгжлийн сангаас 700.0 мянган төгрөгийн туслалцаа үзүүлэн 6 мастер хуур, өөрсдийн хүч бололцоог дайчлан 20-иод морин хууртай болоод байна.</p> <p>"Монгол хөөмий" хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөр болон төлөвлөгөөг боловсрууллаа. Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын уран бүтээлчдийн дунд 1 сарын хугацаатай хөөмийн сургалт явуулж, сургалтанд 5 уран бүтээлч хамрагдлаа. 2009 оны 5 сарын 8-10-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Монгол Хөөмийн олон улсын симпозиум-ИХ НААДАМД АДБ-ийн "Хан Хэнтий" чуулгын хөөмийч Б. Энхбаяр, Л.Энхнаран нар оролцсон.</p> <p>"Монголын уламжлалт Бий, биелгээ" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын уран бүтээлчид "Хэнтийн дэг багт цам" бүжиг, 3 уран бүтээлчдийн "Намбат бүжгийн дэг" тоглолт, "Хөдөөгийн одод" Монголын урлагийн их чуулган зэрэг тоглолт зохион байгуулан шинэ уран бүтээл туурвин өргөн олонд толилуулж, мөн Говьсүмбэр аймгийн "Боржигон" чуулга, Сүхбаатар аймгийн "Жаахан шарга" ХДТеатрийн уран бүтээлчидтэй туршлага солилцох уулзалт хийж, шинэ уран бүтээлээ толилууллаа. "Цөвүүн цагийн хяруу" рок мюзикл тоглолтыг шинээр туурвин хөрш зэргэлдээх аймгуудад аялан тоглолт хийлээ. 2009.12.17-19нд Монголын Уламжлалт Язгуур урлагийн "Бий биелэгээ" холбоотой хамтран зохион</p>	<p>30</p>

		байгуулсан сургалтанд бүжгийн багш 12, Соёлын төвийн төвийн эрхлэгч 20 нийт 32 соёлын ажилтанг хамруулан Аймгийн “Бий, биелгээ” холбооны салбар хороо байгууллаа.	
<b>4.4. Нийгмийн халамж, хөдөлмөр</b>			
69.	Ядууст чиглэсэн, харьцангуй чинээлэг дунд давхаргыг төлөвшүүлэх эдийн засгийн бодлого хэрэгжүүлж, орлогын өсөлтийг хангах замаар ядуурлыг хоёр дахин бууруулна 4.1.	Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсээс 2009 онд явуулсан хүн амын ядуурлын түвшинг тогтоох судалгаанд аймгийн хэмжээнд 19511 өрх хамрагдаж, 7261 өрх буюу нийт өрхийн 37,2 хувь нь ядуу гэсэн дүн гарсан бөгөөд 2008 онд ажилгүйдлийн түвшин 3,9 хувь байсан бол 2009 онд 3,3 хувь болж 0,6 хувиар буурсан байна.	10
70.	Ядуурлыг бууруулахад бүхий л хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог хангасан зохицуулалтыг бий болгож, ядуурлын түвшинг эрчимтэй бууруулна 4.1	2009 онд нийт 363 өрхийг ядуурлаас гаргахад бодит дэмжлэг үзүүллээ. Энэ зорилтын хүрээнд төсвийн болон, олон улсын хөтөлбөр, төсөл, аж ахуй нэгж байгууллагуудын дэмжлэгтэйгээр амьжиргааны түвшин доогуур өрхийн ажилгүй иргэдийг "Нэг өрх-нэг ажлын байр" хөтөлбөрт хамруулан байнгын болон түр ажлын байранд зуучлах, ахуйн үйлчилгээ, зочид буудал, цайны газар, оёдолын чиглэлээр мэргэжлийн сургалтанд хамруулах, бичил зээл олгох, хүнсний ногоо тариалахад нь зориулж ногооны үр олгох зэргээр 18,4 сая төгрөгийн санхүүжилт хийсэн байна. Мөн 31 өрхөд 1,6 сая төгрөгийн эсгий туурга олгов. Аймгийн хэмжээнд "Тогтвортой амьжиргаа-2" төслийн хүрээнд байгалийн гамшигт өртөж малгүй болсон 8 сумын 420 өрхөд 300,6 сая төгрөгийн 10020 толгой мал олгоод байна. Италийн төрийн бус Аифо байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа “Тэгш дүүрэн” хөтөлбөрийн хүрээнд Баянхутаг, Мөрөн, Биндэр, Хэрлэн сумын Тахилгат тосгоны хөгжлийн бэрхшээлтэй болон ядуу 35 өрхийг малжуулах төсөлд хамруулсан.	30
71.	Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг үндэсний соёлын дэвшилтэт уламжлал, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололттой хослуулан төлөвшүүлнэ 4.2	Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх 20 заалт бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. 2009-2010 оны хичээлийн жилд статистик мэдээллээс үзвэл IX ангид суралцагчдын 49.2%, X ангид суралцагчдын 54.3%, XI ангид суралцагчдын 55.4%-ийг эмэгтэй сурагчид эзэлж байна. Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа нийт сурагчдын хүйсийн тэнцвэржилтийн байдал 2005 онд 52.2%, 2006 онд 53.4%, 2007 онд 50.7%, 2008 онд 49.7%, 2009 онд 49,1%-тай байна. Сүүлийн жилүүдэд суурь боловсрол олгох ангид суралцагчдын дотор хөвгүүдийн эзлэх хувь нэмэгдэж сургууль завсардалт буурсан байна. Удирдах болон шийдвэр гаргах түвшинд ажиллагсадыг хүйсээр харьцуулан авч үзэхэд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн 20% эмэгтэйчүүд, 80 %-ийг эрэгтэйчүүд эзэлж байна. Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилтнуудын 85.4%, удирдах ажилтнуудын 82.1%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Боловсролын салбарт ажиллаж байгаа нийт багш нарын 81.3%-ийг, удирдах ажилтнуудын 68.5%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Сумдын Засаг дарга нарын 20%, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарын 11,7%, орлогч дарга нарын 33%, Засаг даргын Тамгын газрын дарга	30

		нарын 27,2%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын 30%-ийг эмэгтэйчүүд, төрийн үйлчилгээний салбарт ажиллаж байгаа удирдах ажилтнуудын 75,3%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна.	
72.	Гэр бүлийг хүний аж төрөх таатай орчин болгоход чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлнэ 4.3	<p>Хүн ам, гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр 2009 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжинд 28009 хүүхэд хамрагдаж 940,1 сая төгрөг, шинээр гэр бүл болсон 754 өрхөд 376,6 сая төгрөг, шинээр төрсөн 1901 хүүхдэд 190,0 сая төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох тусламжид 3429 эх хамрагдаж 256,8 сая төгрөг, жирэмсэн хөхүүл нярай хүүхэдтэй 2670 эхэд 393,7 сая төгрөг олгосон байна.</p> <p>Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэдийн хэрэгцээнд тулгуурлан зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах үйлчилгээнд 280 иргэн хамрагдаж 22.5 сая, орлогын эх үүсвэртэй болоход нь туслах үйлчилгээнд 25 иргэн хамрагдаж 4,5 сая төгрөг, сэргээн засах үйлчилгээнд 50 иргэн хамрагдаж 7,7 сая төгрөг, түр байршуулан асрамжлах үйлчилгээнд 18 иргэнд 5,0 сая төгрөг нийт 39,8 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцох нөхцлийг бүрдүүлэх зорилгоор аймаг, сумдын ахмадын байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоотой хамтран нийгмийн хамгааллын талаар төрөөс хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилтийг хангахад хамтран ажиллаж байна.</p>	30
73.	Хүн амын эмзэг бүлгийн хөгжлийг дэмжих хүний эрхэд суурилсан гэр бүл төвтэй төрийн цогц бодлого хэрэгжүүлнэ 4.3	<p>2009 онд ажлын байранд зуучлах үйлчилгээний хүрээнд 1471 иргэн зуучлагдаж хамрагдсан иргэдийн 956 буюу 65 хувь нь байнгын ажлын байртай болж 6,1 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Нийтийг хамарсан ажилд 1042 хүн хамрагдаж 120,9 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж хамрагдагсдын 70 хувь буюу 730 иргэн эмзэг бүлгийн иргэд бөгөөд түр ажлын байраар хангагдсан. Мөн "ХААН", "Монгол шуудан", "Хас" банкаар дамжуулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 164 иргэнд 161.3 сая төгрөгийн бичил зээл олгож шинээр 249 ажлын байр бий болсон. 2009 онд нийт 363 өрхийг ядуурлаас гаргахад бодит дэмжлэг үзүүллээ. "Нэг өрх-нэгээс доошгүй ажлын байр" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Баянмөнх сум талх нарийн боовны үйлдвэрлэл эрхлэх 2 иргэнд, Биндэр суманд гагнуур, машин засвар ажиллуулах 1 өрх 3 иргэнд, Батширээт суманд зочид буудал ажилуулах 1 өрх 3 иргэнд, Мөрөн суманд хүнсний ногоо тариалах 1 өрх 4 иргэнд дэмжлэг үзүүлэх төслийг дэмжиж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 14,5 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Улаанбаатар хотын сургалтын төвүүдтэй хамтран сантехник, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, касс худалдагч, гар урлал, үсчин, мужаан, гар утасны засвар, нарийн боов, оёдол зүймэл, нарийн боовчин, байгууллага дээрх сургалт, малчдын болон аж ахуй эрхлэлтийн сургалт, үйлчилгээний ажилтан, бизнесээ хөгжүүл, агропарк ногоочдын сургалт, нийгмийн хамгаалал, бизнесийн хөгжлийг дэмжих сургалт, мэдээлэл зөвлөгөө өгөх сургалтанд 746 иргэн хамрагдаж Хөдөлмөр эрхлэлтийг</p>	30

		дэмжих сангаас 53.9 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.	
74.	Эцэг, эх үр хүүхдээ эрүүл, саруул өсгөн бойжуулж, боловсрол хүмүүжлийн зөв төлөвшилтэй болгон хөгжүүлэхэд чиглэсэн гэр бүлийн таатай орчныг бүрдүүлэхийг төрөөс дэмжинэ. Төрөлтийг дэмжих замаар хүн амын жилийн дундаж өсөлтийг нэмэгдүүлж, улмаар хүн амаа өсгөх бодлого баримтална 4.3	“Хүүхдийн хөгжил хамгаалыг сайжруулах” хөтөлбөрийг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлснээс гадна НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Хэрлэн суманд "Хүүхдийн гэмт хэргийн асуудал хариуцсан хороо"-г байгуулан ажиллуулж байна. Нийгмийн болон гэр бүлийн дунд хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх өрөөг тохижуулан ажиллуулж 40 гаруй эцэг эх, хүүхдэд зөвлөгөө өгч ажилласан. Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах салбар төв 2009 оны 2-р сараас үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. Хүчирхийлэл, дарамтанд өртсөн хүүхдэд нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг тусалцаа үзүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, улмаар таслан зогсооход чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг уг төрийн бус байгууллага нь Хэрлэн сумын 5 баг дээр зохион байгуулагдсан Хамтарсан багийн бүрэлдэхүүнд орж ажилладаг бөгөөд олон нийтэд хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар сургалт сурталчилгаа хийх мөн тодорхой кейс дээр хамтарсан багийн гишүүдтэй хамтран ажиллаж байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн Хүүхдийн төлөө хэлтсээс 800,0 мянган төгрөгийн хөрөнгө зарцууллаа. 2009 оны байдлаар 1560 эх төрсөн нь 2008 оны мөн үеийнхтэй харьцуулахад 7,62 хувь буюу 119 төрөлтөөр өссөн байна. Жирэмсний хяналтанд 1636 эхийг хяналтанд авснаас 83,0 хувь нь эхний 3 сартай хяналтанд орсон байна.	30
75.	Хүүхэд эхээс төрсөн цагаасаа зургаан нас хүртэл гэр бүл, эсхүл түүнтэй дүйцэх орчинд өсөж торних, зөв хүмүүжил, ёс суртахуунтай болох, сургуулийн өмнөх боловсрол олгоход төрөөс онцгой анхаарна 4.3	2009-2010 оны хичээлийн жилд 6 настай нийт хүүхдийн 93,4 хувийг ЕБС-д хамруулан сургаж байгаа ба үлдсэн хувь өөр аймаг, хотод суралцаж байгаа болно. 2009-2010 оны хичээлийн жилд цэцэрлэгийн насны 5237 хүүхдээс 4112 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж, хамран сургалт 78,5%-д, бага боловсролын хамран сургалт 97%, суурь боловсролын хамран сургалт 99,7%-д байгаа нь аймгийн Засаг даргын БСШУ-ны сайдтай байгуулсан гэрээний зорилтыг хангалаа.	30
76.	Гэр бүл, нийгэм, хамт олонд тулгуурласан халамжийн тогтолцоог төлөвшүүлж, халамжийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэж хөгжүүлнэ 4.8	Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах үйлчилгээнд 280 иргэн хамрагдаж 22.5 сая төгрөг, хөдөлмөр эрхэлж, орлогын эх үүсвэртэй болоход нь туслах үйлчилгээнд 25 иргэн хамрагдаж 4.5 сая зарцуулагдсан байна. Мөн сэргээн засах үйлчилгээнд 50 иргэнд 7.7 сая төгрөг, түр байршуулан асрамжлах үйлчилгээнд 18 иргэн хамрагдаж 5.0 сая төгрөг нийт 39.8 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. 2009 онд 28009 хүүхдэд 940,1 сая төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмж сангаас мөн 28009 хүүхдэд 2688,1 сая төгрөгийг хүүхдийн хөгжил сангаас тэтгэмжийг цаг хугацаанд нь олгосон.	30
77.	Иргэний хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүтээмж, ур чадварыг хөгжүүлэх үндсэн дээр цалин	Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээр дамжуулан бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа иргэдээс 1471 иргэнийг байнгын болон түр ажлын байранд	30

	хөлсийг нэмэгдүүлэх, бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн түншлэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг оновчтой, үр ашигтай болгож, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ 4.8	зуучилсан. “Нэг өрх-нэгээс доошгүй ажлын байр” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 4 сумын 4 өрхийн 12 иргэнд ажлын байрны төслийг санхүүжүүлэх зорилгоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 14.5 сая төгрөг олгосон.	
78.	Хүн амын бүлгүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлт, түүний дотор нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ 4.8	Аймгийн хэмжээнд нөхөрлөл,бүлгийг дэмжих арга хэмжээний хүрээнд 140 иргэн хамрагдаж 15,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна."Нэг өрх-нэг ажлын байр" хөтөлбөрийн хүрээнд 5 сумаас ирүүлсэн төслүүдэд 17,5 төгрөгийг олгосон.Мөн "Ногоон ажлын байр" хөтөлбөрт 10 сумаас ирүүлсэн төслүүдэд 16,2 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж 155 иргэн хамрагдсан байна.2009 онд нийтийг хамарсан ажилд 1042 хүн хамрагдаж 12,9 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, нийт хамрагдагсдын 70 хувь буюу 730 эмзэг бүлгийн иргэд түр ажлын байраар хангагдсан.	30
79.	Нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно 4.8	2009 онд нийгмийн даатгалын сангуудад нийт 61055845.9 мянган төгрөгийн шимтгэл төвлөрүүлэхээс 5704051.7 мянган төгрөг хуримтуулан орлогын төлөвлөгөөний биелэлт 93.4 хувьтай байна.Нийгмийн даатгалын байгууллага нь 580 ажил олгогч,10371 заавал даатгуулагч,1637 сайн дурын даатгуулагч,10 эмнэлэг, 2 рашаан сувилал,19 эмийн сантай хамтран ажилласан.	30
<b>5.0. Бусад чиг үүргийн салбар</b>			
<b>5.1. Хууль зүй</b>			
80.	Төрийн институцүүдийг чадавхжуулж, төрийн үйлчилгээг ил тод, хүртээмжтэй болгох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно 7.1	Төрийн үйлчилгээг ил тод, хүртээмжтэй болгох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд “Төрийн байгууллагын шударга ёс, ил тод байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсгийг байгуулж авлига хүнд суртлын шалтгаан нөхцлийг судлан тогтоох зорилгоор нийт 1475 иргэнээс санал асуулга, судалгаа авсан бөгөөд дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэж, 11 заалт бүхий албан даалгавар гарган холбогдох албан тушаалтнуудад хүргүүллээ. Төлөвлөгөөний төслийг олон нийтийн оролцоонд тулгуурлан боловсруулж, АТГ-аас санал авч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 103 тоот тогтоолоор батлуулан, хэргжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн 35% болох 8.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулах шийдвэр гаргуулан ажиллаж байна. Монгол улсын Засгийн газраас баталсан “Нэг цонхны үйлчилгээ” байгуулах дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд 2009 оны 4 сарын 27-нд “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвийг нээж, төрөөс үзүүлж буй төрөл бүрийн үйлчилгээг нэг газраас олон төрлийн хэлбэрээр буюу “нэг цонх”-ноос үзүүлж,	30

		үйл ажиллагаа нь тогтмолжоод байна.	
81.	Хүний эрхийг баталгаатай хангана 7.1	<p>Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн аймгийн салбар хороог аймгийн Засаг даргын 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 123 дугаар захирамжаар шинэчлэн байгуулан, 21 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.</p> <p>Хүний эрхийн салбар хорооны хуралдаанараа 2009 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөгөө батлан орон нутгийн төсвөөс 2.105.000 төгрөгийг төсвийн ерөнхийлөн захирагч багцаасаа батлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа. Монгол улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооны ажлын алба, Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран 12 дугаар сарын 21-ний өдөр Сумдын ХЭХҮХСХорооны дарга, нарийн бичгийн дарга нарт зориулсан сургалтыг зохион байгууллаа.</p> <p>Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг нь дэмжин идэвхижүүлэхэд ажлын хүрээнд “Монгол улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Төрийн бус байгууллагын оролцоо” сэдэвт чуулга уулзалтанд Төрийн бус байгуулагаасаа нэг төлөөлөгч оролцуулсан. Аймгийн прокурор, шүүгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч шүүхийн шийдвэр биелүүлэх албаны ажилтан нарт “Хүүхэд ба хууль ёс сургалт”-г Хүүхэд хамгааллын хорооноос мэргэжлийн сургалтын баг урьж, 2009 оны 11 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгууллаа.</p>	30
82.	Нийгэм дэх аюулгүй орчныг бий болгох эрх зүйн орчинг боловсронгуй болгоно 7.1	<p>Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 06 сарын 02-ны өдрийн 50 дугаар тогтоолоор “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн дүрмийг, 2009 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор “Мал, мах түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ, түүнийг хэрэглэх журам”-ыг, 2009 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор “Иргэдээс гэмт хэргийн тухай мэдээллийг төлбөртэй авах журам”-ыг тус тус батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд 2009 оны 12 дугаар сарын 4-нд РС тогмоомын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн захирал, МХГ,Цагдаагийн алба хаагчид, төрийн захиргааны ажилтнууд оролцсон уулзалт ярилцлага хийж аймгийн хэмжээнд цахим тоглоомын ажиллах журамын төсөл танилцуулан, санал авсан. Аймгийн Засаг даргын 2009 оны 322 дугаар захирамжаар Цахим тогмоом ажиллуулах нийтээр дагаж мөрдөх журам батлан гаргалаа.</p>	30
83.	Улс төрийн тогтолцоог боловсронгуй болгож, ардчилалыг гүнзгийрүүлэн хөгжүүлнэ 7.1	<p>Хэнтий аймгийн төрийн бүх шатны байгууллагууд,төрийн албан хаагчид үйл ажиллагаандаа шударга ёс, ил тод байдлыг эрхэмлэн зөвхөн хууль ёсонд захирагдаж, төрийн албаны болон иргэдийн нийтлэг ашиг сонирхлын төлөө ажиллахаа мэдэгдэж, улсын хэмжээнд анх удаа уриалга гаргалаа. Энэхүү уриалгыг хэрэгжүүлэхийн тулд аймгийн ИТХТ-ээр "Төрийн байгууллагын шударга ёс, ил тод байдлын төлөвлөгөө" -г батлуулан мөрдөж ажиллаж байна. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд ажиллаж байгаа ТЗАХ болон</p>	30



		<p>төсөвт байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн удирдлагуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг авч АТГ-т хүргүүлэн ажиллаж байна. 2009 онд сум, байгууллагуудын удирдлагуудад 2 удаа сургалт семинар өгч, гарын авлага, сурталчилгааны материалаар хангав. АТГ-ын аймаг хариуцсан ажилтантай байнгын харилцаатай, хамтран ажиллаж байна. Төрийн албаны тухай хуулийн 10.6 дахь заалтыг биелүүлэх ажлыг зохион байгуулж сум, албан байгууллагуудад албан тоот хүргүүлж, судалгааг гарган Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн бөгөөд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын дарга нар болон ЗДТГ-ын нийт албан хаагчдын улс төрийн намаас түдгэлзсэн тухай өргөдөл, намын хороодоос ирүүлсэн түдгэлзэн тухай баримтыг хувийн хэрэгт хавсаргав.</p>	
84.	<p>Парламентын тогтолцоог төлөвшүүлэн хөгжүүлж, төрийн бодлогын тогтвортой байдлыг хангана 7.2</p>	<p>Аймгийн хэмжээнд явуулах эрх зүйн сургалт сурталчилгаа, мэдээллийн ажлын хөтөлбөрийн хүрээнд Эрх зүйн туслалцааны төв, УИХ-ын үйл ажиллагааг сурталчилах төвийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, УИХ-ын үйл ажиллагааг ард түмэнд сурталчилан таниулах, иргэдийг эрхзүйн мэдээлэлээр хангах, тэдэнд эрхзүйн туслалцаа үзүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Төвийн эрх зүйн лавлагааны санд төрийн мэдээлэл болон хууль зүйн мэдээлэл сэтгүүлийг тогтмол захиалан ашиглаж байгаа бөгөөд эрхзүйн бүртгэл лавлагааны цахим сангаас шинээр батлагдсан хууль, хуулинд орсон нэмэлт өөрчлөлт, хүчингүй болсон хууль болон УИХ-ын тогтоолуудыг иргэдэд мэдээлэх, сурталчилах бүрэн боломжтой болсон. 2009 онд Засгийн газрын тогтоол-50, Ерөнхий сайдын захирамж-4, Албан даалгавар-4, Хурлын тэмдэглэл-12, УИХ-ын тогтоол-2 ирсэн байна.Тус төвөөр үйлчлүүлэх, мэдээлэл авч байгаа иргэдийн тоо сүүлийн үед тогтмол өсч байна.</p> <p>Шинээр батлагдсан хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлт, хөдөлгөөнийг мэдээлэх сурталчилах ажлыг сум, байгууллагын мэдээллийн цаг хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байгаагаас гадна мэргэжлийн байгууллагууд, агентлагуудаас зохион байгуулж байгаа сургалт, семинарын төлөвлөгөөнд “эрхзүйн орчны шинэчлэлт” гэсэн сэдвийг заавал оруулж, тухайн салбарын хууль тогтоомж, өөрчлөлт хөдөлгөөний талаар мэдээлэлийг өгч байгаа нь үр дүнтэй ажил болж байна. Зарим албан газар, байгууллагууд Хууль зүйн хэлтэстэй хамтран албан хаагчдынхаа эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сургалт, семинарын жилийн төлөвлөгөөндөө эрхзүйн сургалтын 1-3 сэдвийг тусгаж хэрэгжүүлж ажиллаж байна.</p>	30
85.	<p>Төрийн удирдлагын шийдвэр гаргах үйл явцын ил тод байдал, түүнд иргэд оролцох боломжийг хангана 7.2</p>	<p>Шударга ёс ил тод байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж төлөвлөгөөний төслийг олон нийтийн оролцоонд тулгуурлан боловсруулж 2009 оны 9 сарын 30 ны өдөр ИНБС, ИТХ-ын төлөөлөгчид, иргэний зөвлөлийн гишүүд 36 хүн оролцсон хэлэлцүүлгийг ИНБС-тэй хамтран зохион байгуулж, 2009 оны 12-р сарын 10-11 өдрүүдэд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид, иргэдийн дунд ярилцлага зохион байгуулж тэдний гаргасан саналыг</p>	30

		<p>Шударга ёс ил тод байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд тусгаж, АТГ-аас санал авч аймгийн ИТХТ-ийн хуралдаанаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж эхлээд байна. Засаг дарга бүх сумаар 1-3 удаа явж ажил байдалтай газар дээр нь танилцаж асуудлыг шийдвэрлэж ажилласан ба оны эцэст өөрийн хийсэн ажлын тайлан болон тухайн сумын Засаг дарга нарын тайланг иргэдэд танилцуулж, нийтдээ 2000 гаруй иргэдийг хамруулан зохион байгууллаа. Аймаг орон нутагт тулгамдсан асуудлаар Засаг даргын зөвлөл 18 удаа хуралдаж, 34 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, хуралдааны бүх үйл ажиллагааг аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр иргэдэд дамжуулж, ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллав. Шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах зорилгоор аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын бүрэлдэхүүнд Иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээний тэргүүнийг оролцуулан бүх хуралдаанд идэвхтэй хамрагдаж ажиллаа.</p> <p>2009 онд Засаг дарга агентлагийн дарга нартай 3 удаа, сумдын Засаг дарга нартай 3 удаа, аймгийн бүх 83 багийн Засаг дарга нартай 1 удаа ажил хэргийн уулзалт зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр уг уулзалтуудын үйл ажиллагаа, шийдвэрийг иргэдэд мэдээллээ.</p> <p>Иргэдийн санал хүсэлт хүлээн авах шууд утсаар 29 иргэний 32 гомдол хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн ба иргэдээс аймгийн Засаг даргад хандан уулзалт хурал дээр болон бичгээр ирүүлсэн нийт 475 өргөдөл гомдол хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, 2009 онд аймгийн Засаг дарга захирамжаар 46 хүнд 2 сая 130 мянган төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүллээ.</p>	
86.	Шүүх эрх мэдлийн байгууллагын хараат бус, шударга үйл ажиллагаа явуулах орчин нөхцөлийг бүрдүүлнэ 7.2	Шүүх эрх мэдлийн байгууллагын хараат бус, шударга үйл ажиллагаа явуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд аймгийн Прокурорын газрын тохижилт, техник хэрэгсэл худалдан авахад нь зориулж 1.0 сая төгрөгийн туслалцаа үзүүлж ажиллалаа.	30
87.	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийг эдийн засгийн чадамж, хүн амын нөөцөд тулгуурлан томсгоно 7.2	Орон нутгийн түвшинд гарах боломжгүй	-
88.	Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлнэ 7.6	Орон нутгийн хамгаалалтанд тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэхэд нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг 2010 оны 3-р сарын 3-аас 13-ыг хүртэл хугацаанд 60 хүнийг сургалтанд хамруулаад байна. Үүнээс 20 хүнийг Инженерийн тагнуулчин, 20 хүнийг Химийн цэвэрлэгч, 20 хүнийг Жаргалтхаан суманд Дизельчин гэсэн 3 төрлийн мэргэжлээр сургалт явууллаа.	10
89.	Зэвсэгт хүчний ерөнхий удирдлага, иргэний хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, олон талт үүрэг гүйцэтгэх чадамж бүхий мэргэшсэн болгон хөгжүүлнэ 7.6	Дадал суманд байрлах Хилийн цэргийн 287 дугаар ангид гэрээт хилчин 3 байгаа ба 2009 онд 1 хүн гэрээт цэргийн албанд орох хүсэлтээ гаргаад байна. Гэрээт цэргийн тоог нэмэгдүүлэх зорилгоор сонирхогч иргэдэд энэ чиглэлийн мэдээлэл өгч, зар хүргэж байгаа боловч зохих шаардлага хангасан иргэд ирэхгүй байна.	10

90.	Зэвсэглэл, шинэчлэлийг хэрэгжүүлнэ 7.6	техникийн үе шаттай	Зэвсэглэл техник байхгүй тул аймгийн хэмжээнд биелэлт тооцох боломжгүй	-
<b>5.3. Гадаад харилцаа</b>				
91.	Энхийг гадаад хэрэгжүүлнэ 7.5	эрхэмлэсэн, улс төрийн идэвхтэй бодлогыг	Хил залгаа БНХАУ, ОХУ болон тэдгээрийн муж хотуудтай эдийн засаг, нийгэм, хөдөө аж ахуйн салбаруудад хамтран ажиллаж байна. 2009 онд гадаад харилцаагаа өргөжүүлэн ӨМӨЗО-ны Хөх хоттой хамтран ажиллахаар санал солилцож, санамж бичигт гарын үсэг зурлаа.	30
92.	Эдийн засгийн харилцааг хөгжүүлнэ 7.5	үр ашигтай гадаад	2009 онд ӨМӨЗО-ны Хөх хотын Ардын засгийн газраас Дадал суманд аялал жуучлал хөгжүүлэхэд 10,0 мянган долларын дэмжлэг үзүүлсэн.	30
93.	Бусад харилцааг эрчимжүүлнэ 7.5	салбарын гадаад	Цаашид гадаад харилцааг харилцан ашигтайгаар хөгжүүлэх зорилт тавьж, Бүгд Найрамдах Унгар улсад суугаа элчин сайд О.Эрдэнэчимэгт тус улсын аль нэг муж, хоттой хамтын ажиллагаа эхлүүлэх санал, ӨМӨЗО-ны Ардын Засгийн газрын Гадаад Хэрэг эрхлэх газрын дарга Жан Вэйд хөрөнгө оруулалт, худалдаа, эдийн засаг, боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, спорт, аялал жуулчлалын чиглэлээр хамтын ажиллагаа эхлүүлэх санал тус тус хүргүүлээд байна.	10
<b>5.4. Удирдлагын ерөнхий чиг үүргийн салбар</b>				
<b>5.4.1. Гүйцэтгэх засаглал</b>				
94.	Төрийн удирдлагын төлөвлөлт, гүйцэтгэлийн чадамжийг хөгжүүлнэ 7.3	албаны стратегийн гүйцэтгэлийн	Удирдах албан тушаалтны сул орон тооны сонгон шалгаруулалтыг иргэдэд ил тод нээлттэй байлгах үүднээс зарыг орон нутгийн телевиз, FM радиогоор тухай бүр явуулж хэвшсэн. 2009 онд 17 удирдах албан тушаалтны сул орон тоо нийтэд зарлагдсан бөгөөд үүнд 42 иргэн өрсөлдөж 35 иргэн тэнцэж 7 иргэн тэнцээгүй. Сонгон шалгаруулалтанд хамгийн өндөр оноо авсан 17 иргэн тухайн албан тушаалд томилогдон ажиллаж байна. Төрийн жинхэнэ албан тушаалын 64 ажлын байрны 89 сул орон тоон дээр 593 хүн бүртгүүлж 587 хүн шалгалтанд орсноос 146 хүн тэнцсэн байна. Сул ажлын байранд 52 хүн томилогдон ажиллаж байна.	30
95.	Төрийн шинжилгээний албан хаагчийн чадамжийг шинэ түвшинд хүргэнэ 7.3	албаны бодлого, дүн болон төрийн манлайллын	Хөтөлбөрийн хүрээнд Төрийн албаны зөвлөл дээр сургагч багшаар бэлтгэгдсэн аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, Мэргэжлийн хяналтын газрын дарга, Тэмүүжин цогцолбор сургуулийн захирал нар 2007 оны 9 сараас -2009 оны эхний хагас жилийн байдлаар 17 сумын 90 төсвийн байгууллагын ерөнхий менежер, Засаг даргын дэргэдэх агентлагуудын ерөнхий менежерүүдэд 3 үе шаттай сургалтыг зохион байгуулж, 2010 онд бүрэн хамруулж дуусгах зорилт тавин ажиллаж байна.	30
96.	Төрийн хангаж, чанар, хүртээмжийг хэмжээг үйлчилгээний дээшлүүлнэ 7.3	албаны оновчтой хэмжээг үйлчилгээний	Төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, ил тод, иргэд байгууллагад хүртээмжтэй болгох зорилгоор Монгол улсын Засгийн газраас баталсан “Нэг цонхны үйлчилгээ” байгуулах дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд 2009 оны 4 сарын 27-нд “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвийг нээж, төрөөс үзүүлж буй төрөл бүрийн үйлчилгээг нэг газраас олон төрлийн хэлбэрээр буюу “нэг цонх”-ноос үзүүлж байна. Уг төв иргэдэд	30

		нийгмийн даатгал, хөдөлмөр халамж, иргэний бүртгэл, мэдээлэл, газрын харилцаа, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, зөвлөмж, мэдээлэл өгөх, банк, нотариат гэх мэт олон чиглэлээр нэг дор үйлчилгээ үзүүлж байгаа нь иргэдийн талархлыг хүлээсэн арга хэмжээ боллоо. Нэг цонхны үйлчилгээнд 2009 онд нийтдээ 24921 иргэн хамрагдаж төрийн үйлчилгээг нэг дороос авсан байна. Үйлчлүүлэгчдээс авсан санал асуулгаар 88% нь нэг цонхны үйлчилгээний төвөөс хүссэн үйлчилгээгээ авч чадсан байна.	
97.	Олон улсын чанартай уламжлалт бус аюулаас урьдчилан сэргийлэх болон байгалийн гамшиг ослоос хүн амыг хамгаалахад чиглэсэн гадаад хамтын ажиллагааг хөгжүүлнэ 7.4	ОХУ-ын Эрхүү мужид гал унтраах ангийн салаан захирагчийн 14 хоногийн сургалтанд 1 албан хаагч, ОХУ-ын гал эсэргүүцэх албаны академи, цагдаагийн академийн галын техникчийн ангид нийт 5 албан хаагч суралцаж байна.	30
98.	Эдийн засгийн эрчимтэй хөгжил, улс төр, нийгмийн тогтвортой байдлыг хангах, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн үндэсний аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлнэ 7.4	Байгаль орчныг хамгаалах, түүний нөөц баялгийг зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх хяналтыг сум, багийн түвшинд хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий идэвхтэн байгаль хамгаалагч 2009 онд Хэрлэн суманд 8, Дадал суманд 5 шинээр томилсон. Байгаль хамгаалагчдын ажлын нөхцөлийг сайжруулж дуран, бороохой, мотоцикль, дүрэмт хувцасаар хангасан.	10
99.	Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын тухай, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай зэрэг хууль тогтоомжийг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын зорилтуудтай уялдуулан өөрчилж, эдгээр хууль тогтоомж, үзэл баримтлалын хэрэгжилт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн гүйцэтгэлд хяналт тавих, биелэлтийг дүгнэх цэгцтэй тогтолцоог бүрдүүлнэ 7.4	Монгол улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Монгол Улсыг хөгжүүлэх цогц бодлого батлагдаж түүний хэрэгжилтийг шалгах шалгуур 67 үзүүлэлтийг 2008 оны 13 дугаар тогтоолоор батлан мөрдөж байна. Үүнтэй уялдуулан аймаг өөрийн онцлогт тохирсон “Хэнтий аймгийн хөгжлийн цогц хөтөлбөр” /2008-2021 он/-ийг Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, ШУА-ын үндэсний хөгжлийн хүрээлэнтэй хамтран боловсруулах ажлыг хийж, аймгийн Засаг даргын зөвлөл, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна. Дээрх хөтөлбөр түүнтэй уялдан гарсан аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг үндэслэн аймаг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээ боловсруулах, дунд болон урт хугацааны төсвийн бодлогыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, зохицуулалтыг хийн ажиллаж байна.	30
<b>5.4.2. Санхүү</b>			
100.	Төсвийн төлөвлөлтийг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд нийцүүлэн боловсронгуй болгоно 5.1.1	Хэнтий аймаг нь Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого-д тулгуурлан “Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого, төлөвлөгөө (2009-2021 он)”-г боловсруулан аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулахад бэлэн болоод байна. Дээрх аймгийн хөгжлийн цогц бодлого болон аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх дунд хугацааны үндсэн чиглэлд тулгуурлан тус аймгийн улсын болон орон	10

		нутгийн төсвийн төлөвлөлтийг боловсруулж байна. Манай аймаг 2009 онд орон нутгийн төсөвтөө 4390.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, төлөвлөгөөг 441.6 сая төгрөгөөр буюу 11.2 хувиар давуулан биелүүлж, төсвийн тэнцлээр улсын УТТ-т 470.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Төсвийн төлөвлөх, мэдээлэх, тайлагнахтай олбогдсон үйл ажиллагааг ил тод байлгах зарчмыг баримтлан ЗДТГ-аас гаргаж буй мэдээлэл сэтгүүл, байгууллагын мэдээллийн самбараар иргэд хөдөлмөрчдөд шаардлагатай мэдээллийг хүргэн ажиллаж байна.	
101.	Төсвийн хөрөнгө оруулалтыг Мянганы хөгжлийн зорилтуудтай оновчтой уялдуулан нэмэгдүүлж, <b>урт, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, төслүүдэд</b> суурилан хэрэгжүүлнэ 5.1.1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 624.4 сая төгрөгийн, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 152,8 сая төгрөгийн, зүүн бүсийн "Бүс нутгийн хөрөнгө оруулалтыг дэмжих" хөрөнгө оруулалтаар 366.5 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олголоо. Орон нутагт хэрэгжиж буй засаглалыг дэмжих ,ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж орон нутгийн төсвөөс 38.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлээд байна.	30
102.	Хүн амын орлого багатай ядуу болон дундаж орлоготой хэсэгт түлхүү хандсан төсвийн зарлагын бодлого хэрэгжүүлнэ 5.1.1	Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу аймгийн орлого багатай ядуу болон дундаж орлоготой хэсэгт анхаарсан төсвийг батлан тодорхой хэмжээний хөнгөлөлт, буцалтгүй тусламж үзүүлж байна. Тухайлбал: Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаагүй 125 өрхөд 200 куб. Метр түлээний мод олгосон. Мөн эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд бүхий өрхийн 200 хүүхдэд 3850.0 мянган төгрөгийн дүрэмт хувцас олгон, 5 хүүхдийн их дээд сургуулийн сургалтын төлбөрийг орон нутгаас бүрэн хариуцсан. Ажилгүйдэл ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд 2009 оны эхний хагас жилийн байдлаар ХААН, Монгол шуудан , Хас банкаар дамжуулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 184 иргэнд 110.0 сая төгрөгийн бичил зээл олгож шинээр 104 ажлын байр бий болгоод байна. Мөн нийтийг хамарсан ажил, ажил олгогчийн урамшуулал,сургалт,зөвөлгөө өгөх,үйлчилгээнд давхардсан тоогоор 1126 хүнд 69643,2 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулаад байна.	30
103.	Төрөөс стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын орд газруудыг ашиглан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн механизмуудыг хэрэглэн хуримтлал бий болгож, "Монгол Улсыг хөгжүүлэх сан"-д төвлөрүүлж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгахад зохистой ашиглана. <b>"Ашигт малтмал" үндэсний хөтөлбөр</b> боловсруулж хэрэгжүүлнэ	Орон нутгийн түвшинд биелэлт гарахгүй.	-

104.	Экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээ, импортыг орлох зарим үйлдвэрлэлийг татварын оновчтой бодлогоор дэмжинэ 5.1.2	Энэ ажлын хүрээнд хийгдсэн ажил байхгүй бөгөөд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр ААН-үүдэд хөнгөлөлттэй зээл олгогдож байгаа, мөн аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна.	10
105.	Экологийн татварыг бий болгож, татварын суурийг өргөтгөн татвар хураалтыг сайжруулж, төсвийн орлогыг зохистой нэмэгдүүлнэ 5.1.2	Татварын бааз суурийг өргөтгөн, орлогын албан татварын хувь хэмжээг бууруулсанаар ААН-үүдийн борлуулалтын орлого өнгөрсөн оноос 3.0 тэрбум төгрөгөөр, төлбөл зохих татварын хэмжээ 40.1 сая төгрөгөөр нэмэгдсэн. Хөрөнгийн татвар төлөгчдийн тоо өмнөх оноос 1298 иргэнээр буюу 24.9 хувиар, төсөвт оруулж буй орлогын хэмжээ 35.3 сая төгрөгөөр буюу 16.4 хувиар өссөн. Хэрэглээний татварын хувьд НӨАТ төлөгчийн тоо өмнөх оноос 24.1 хувиар төсөвт оруулсан орлогын хэмжээ 69.8 сая төгрөгөөр буюу 40.7 хувиар өссөн. Газрын төлбөр өнгөрсөн оныхоос 12.1 сая төгрөгөөр буюу 17.8 хувиар нэмэгдсэн нь газар өмчлөгч, эзэмшигчдийн тоо нэмэгдсэн, Атрын 3 аяны хүрээнд газар тариалангийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ААН, иргэдийг дэмжих бодлого явуулж байгаатай холбоотойгоор орлогын хэмжээ нэмэгдсэн.	30
106.	Бүс нутгийн хөгжлийг татварын бодлогоор оновчтой дэмжинэ 5.1.2	Орон нутгийн түвшинд биелэлт гарахгүй.	-
107.	Инфляцийг оновчтой удирдан, төгрөгийн ханшийг зохистой түвшинд байлгана 5.1.3	Орон нутгийн түвшинд биелэлт гарахгүй.	-
108.	Банк, санхүүгийн тогтолцоо, үйлчилгээг боловсронгуй болгоно 5.1.3	Хэнтий аймгийн төв болон сум орон нутгийн иргэдэд Монголбанк Хэнтий аймаг дахь салбараараа, Хэнтий ХААН банк нь Хэрлэн суман дахь 1 салбар 2 тооцооны төв, мөн Өлзийт тосгоноос бусад 20 сум сууринг хамруулан, нийт 23 нэгжээр, Хас банкны тооцооны 04-р төв нь Хэрлэн суманд 1 тооцооны төв, 1 өргөтгөл, Бор-Өндөр хотод 1 тооцооны төв, 6-н суманд явуулын зээлийн бүтээгдэхүүнээр, МонголШуудан банкны 115-р салбар нь Хэрлэн суманд 1 салбар, сумдын 9 тооцооны төвөөрөө дамжуулан банкны үйлчилгээг хүргэж байгаагаас гадна Хас банкны Бага-Нуур дахь тооцооны төв нь Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал сумдад банкны зээлийн явуулын үйлчилгээг үзүүлж байна. Мөн Хэрлэн суманд 1 банк бус санхүүгийн байгууллага, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адрага сумдад Хас банктай хамтарсан 3 хадгаламж зээлийн хоршоо нь банктай адилтгах үйлчилгээг иргэдэд хүргэдэг. 2009 оны санхүүгийн хямрал банк санхүүгийн салбарт ч мөн адил нөлөөлж арилжааны банкууд бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ цар хүрээг нэмэгдүүлэхээсээ илүү бууруулж, зарим нэг үйлчилгээг бүрэн зогсоход хүрсэн. Үүнтэй уялдуулан зээлийн хүүг бууруулахаасаа илүүтэйгээр хадгаламжийн хүүг бууруулах чиглэл баримталж ажилласан. 2009 онд Хэнтий аймаг дахь банкны систем өөрийн кассаар 5055.6 сая төгрөгийн орлогын, 3472.3 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийж орлогоороо зарлагынхаа 145.6 хувийг хангаж ажилласан. Арилжааны банкууд хадгаламжийн 24	30

		нэр төрлийн бүтээгдэхүүнээр үйлчилж 9531.5 сая төгрөгийг татан төвлөрүүлж, төлөвлөгөөгөө 110 хувиар биелүүлэв. Мөн зээлийн 27 нэр төрлийн бүтээгдэхүүнээр үйлчилж, зээлийн өрийн үлдэгдлийг 17575.7 сая төгрөгт хүргэж, төлөвлөгөөгөө 97 хувиар биелүүлсэн.	
109.	Зээлийн хүүг бууруулж, хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчин бүрдүүлнэ 5.1.3	2009 оны жилийн эцэст Хэнтий аймгийн хэмжээгээр 15468 зээлдэгчийн 17575.7 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байсан. Мөн онд Хэнтий ХААН банкны хувьд ХАА, хөрөнгө оруулалт, орон сууц, бизнесийн зээлүүдийн хүү дунджаар өмнөх оноос 6.6 /жилээр/ хувиар, ХАС банкны хувьд ХАА, хөрөнгө оруулалт, орон сууц, бизнесийн зээлүүдийн хүү дунджаар өмнөх оноос 6.45 /жилээр/ хувиар тус тус буурсан. Монгол шуудан банкны хувьд 2009 онд зээл үйлчилгээг бүрэн зогсоосон тул зээлийн хүүнд ямар нэг өөрчлөлт гараагүй. Орон сууцны болон ипотекийн зээл 696.5 сая төгрөгийг иргэдэд олгож, төлөвлөгөөгөө 93 хувиар биелүүлсэн.	30
110.	Гадаад зээлийн хэмжээг зохистой түвшинд байлгаж, өрийн эрсдэлийг бууруулна 5.1.4	Орон нутгийн түвшинд биелэлт гарахгүй.	-
111.	Өрийн удирдлагыг сайжруулан боловсронгуй болгоно 5.1.4	Орон нутгийн түвшинд биелэлт гарахгүй.	-
112.	Монгол хүнийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлнэ 5.1.5	Орон нутгийн түвшинд биелэлт гарахгүй.	-
113.	Үйлдвэрлэл, үйлчилгээнд өндөр технологийг нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ 5.1.5	Аймгийн ДНБ-ний өсөлт 2008 онд 1,2 хувь байгаа боловч цаашид уул, уурхай, барилга, боловсруулах аж үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарын үйл ажиллагааны өргөжилт, жонш, төмрийн хүдэр, нүүрс зэрэг эрдэс түүхий эдийн олборлолтын өсөлтөөс шалтгаалан эдийн засгийн бодит өсөлт нэлээд өндөр байхаар байна. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлын хүрээнд барилгын материалын үйлдвэрүүдийг шинээр байгуулах ажил эхлэлийн шатандаа байна. Өндөрхаан хотод "Ганцог" ХХК БНХАУлсад үйлдвэрлэсэн хоногт 50 000 шахмал тоосго үйлдвэрлэх хүчин чадалтай, автомат удирдлагатай иж бүрэн үйлдвэрийг оруулж үйлдвэрлэлээ эхлэн 2009 онд зах зээлийн эрэлтээс шалтгаалан 150 000 ширхэг тоосго үйлдвэрлэлээ. 2009 онд Хэнтий аймагт орчин үеийн технологиор тоноглогдсон хоногт 20тн мах боловсруулах махны үйлдвэр ашиглалтанд ороод үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн хоногт 2000 л сүү боловсруулах сүүний үйлдвэр тоног төхөөрөмжөө суурилуулан үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бэлэн болоод байна.	30
114.	Бизнесийн орчинг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ 5.1.5	Орон нутагт хийгдэж байгаа бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын ажилд орон нутгийн компаниудыг түлхүү оролцуулан төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулан ажиллаж байна. Тухайлбал: Орон нутагт барилга угсралтын ажил хийж гүйцэтгэдэг компаниудад орон нутгийн барилгын материалын үйлдвэрлэл эрхэлж буй компаниудаас барилгын материалаа авч, орон нутгаас ажиллах хүчнээ авч ажиллуулсан тохиолдолд тендер шалгаруулахдаа орон нутгийн давуу эрхийг олгох	30

		замаар дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.	
<b>5.4.3. Худалдаа</b>			
115.	Экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг зохистой өсгөнө 5.1.6	Тус аймгийн Хэрлэн суманд "Мах экспорт" ХХК-ний салбар хоногт 120 бод, 250-300 бог нядлаж боловсруулах хүчин чадалтай махны анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр барилга болон тоног төхөөрөмжийн угсралтын ажил дуусч, үйл ажиллагаа нь 2009 оны 8-р сараас ажиллан өдөрт 100 бод нядлаж боловсруулаад байна. Тус үйлдвэр экспортод нийлүүлэх 250 гаруй тн мах боловсруулан байна. Энэхүү үйлдвэр нь 52 ажлын байрыг бий болгоод байна.	30
116.	Импортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг эдийн засгийн хөгжлийн хэтийн чиг хандлагатай оновчтой уялдуулан сайжруулна 5.1.6	Эсгий, эсгий гутал үйлдвэрлэх 2 төсөлд 30 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл, оёдлын үйлдвэрлэл эрхлэх 3 төсөлд 75.0 сая төгрөгийн зээлийг олгосоны дагуу үйл ажиллагаа тогтмолжин бүтээгдэхүүний үйлдвэрдлэж элээд байна. Батширээт сумын "Гурван нэртэй" хоршоо нь монгол үнээний сүүгээр Словак технологийн бяслагийг гар аргаар үйлдвэрлэн зах зээлд борлуулж байна. Цэнхэрмандал сумын "Нугаар хайрхан" хоршоонд Гауда бяслагны үйлдвэрлэл эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэн 12.0 сая.төг, "Мөнхийн дуурлиг" ХХК-нд гурилын үйлдвэрлэлээр 10.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон.	30
<b>5.4.4. Боловсон хүчин</b>			
117.	Байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийг хангана 7.3	Төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдийг манлайлах ур чадвар дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд 2009 онд орон нутагтаа 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд үүнд 10 сумын төсөвийн байгууллагын 40 ерөнхий менежер хамрагдсан. 2009 он Засгийн газрын тэтгэлэгт сертификатын сургалтанд 2 албан хаагч хамрагдаж төгссөн. Төрийн удирдлагаар мэргэшүүлэх дипломын "Улирал"-ын сургалтанд 2 албан хаагч суралцаж байна. "Бодлого боловсруулах, хэрэгжилтэнд хяналт шинэжилгээ үнэлгээ хийх" сургалтанд 3 албан хаагч, Төрийн бодлого, бодлогын шинжилгээ сургалтанд аймгийн Засаг даргын орлогч,ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, төрийн захиргааны удирдах албан тушаалтны манлайлал, удирдах эв дүй сэдэвт сургалтанд аймгийн Засаг дарга, шинээр сонгогдсон сумдын Засаг дарга нар тус тус хамрагдсан. Төрийн жинхэнэ албан тушаалын мэргэшлийн шалгалтыг 2 удаа зохион байгуулсан ба нийт 64 ажлын байрны 89 сул орон тоон дээр 593 хүн бүртгүүлж 587 хүн шалгалтанд орсноос 146 хүн тэнцэж, 52 сул ажлын байранд 52 хүн томилогдон ажиллаж байна	30
118.	Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн болон цалин хөлс, хангамжийн тогтолцоог төгөлдөржүүлнэ 7.3	Аймаг, Сумын Засаг даргын Тамгын газрын бүтцийг Засгийн газрын 2008 оны 67-р тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2009 оны 40-р захирамжаар зохион байгуулалтын бүтцийг шинээр болон шинэчлэн баталж мөрдүүлэх замаар ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах, төсвийн зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 170 байгууллагад 3827 төрийн албан хаагч ажиллаж байгаа дүн мэдээ төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангаар гарсан бөгөөд үүнээс 8 хүн давхар ажил эрхэлж байна. "40000 айл орон сууц" хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд 9 төрийн албан хаагчийг хөнгөлөлттэй үнээр орон сууцаар хангах эрхийн бичиг олгож материалыг орон	10



		сууц, санхүүжилтийн корпорацид хүргүүлээд байна.	
<b>5.5. Салбар дундын чиг үүргийн салбар</b>			
119.	Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгож, бүс нутгийн хөгжлийг түргэсгэнэ 5.4	Зүүн бүс нутгийн хөгжилд гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор Хөрөнгө оруулагчдын уулзалт форумыг 2009 оны 8 дугаар сарын 5-6-ны өдрүүдэд Дорнод аймгийн Чойбалсан хотод зохион байгуулсан ба уг уулзалтаар Хэнтий аймгийг зүүн бүс нутгийн аялал жуулчлалын гол бүс нутаг болгон хөгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд аялал жуулчлалын аймгийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж байна.	10
120.	Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн эдийн засгийн өсөлтийг хөгжлийн хүчин зүйл болгож, Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлнэ. <b>“Хөдөөгийн хөгжил” үндэсний хөтөлбөрийг</b> боловсруулж, хэрэгжүүлнэ 5.4	Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран аймгийг бүсчилэн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх судалгааг хийж дуусган ерөнхий чиглэлийг гаргасан бөгөөд улмаар орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр оруулж хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна. Мөн "Монгол улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр"-ийг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж байна. “Хөдөөгийн хөгжил” үндэсний хөтөлбөр боловсруулагдаагүй болно.	10
121.	Бүс нутгуудад мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавина	Аймгийн хэмжээнд гаргах боломжгүй.	-
122.	Хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг эрс багасгаж, бүс нутгуудад мэдлэгт суурилсан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлнэ 5.4	Хэнтий аймаг нь Баг бүрийг 1,0 саяас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй, эргэн төлөгдөх нөхцөл бүхий хөгжлийн сантай болгох ажил судалгааны шатандаа байна	10
123.	Хувийн хэвшил, Засгийн газрын байгууллагуудын түншлэлийг дэмжин хөгжүүлж, бэхжүүлнэ 5.1.7	Хөдөлмөр нийгмийн зөвшлийг хангах 3 талт хэлэлцээрийн төслийг боловсруулж ажил олгогч, үйлдвэрчний байгууллагаас саналыг аваад байна.	10
124.	Бизнесийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд оролцох Засгийн газрын оролцоог зохистой түвшинд хүртэл хязгаарлана 5.1.7	Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж байна. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас зохион байгуулсан "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй" сургалтанд хамрагдсан. 3 дугаар сарын 15-ны өдөр буюу Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөрт зориулан аймгийн банкны бүхий л салбаруудад хэрэглэгчдэд мэдлэг, мэдээлэл олгох, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээ сурталчилах ажлыг зохион байгуулж Дөлгөөн Хэрлэн FM-106.2 радиогоор мэдээлэл хийлээ. Аймгийн тариаланчдын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулсан бөгөөд уг зөвлөгөөнд үр тарианы үйлдвэрлэл эрхлэдэг аж ахуйн нэгж, ногоочдын төлөөлөл 110 хүн ирж оролцсон. Зөвлөгөөнөөр тариаланчид, ногоочдын гаргасан саналыг шийдвэрлэж аймгийн Засаг даргын шийдвэрээр тариаланчдын ажлыг дэмжиж "Тариаланг дэмжих сан"-г байгуулж 20тн санте сортын төмсний үрийг худалдан авахад шаардагдах 16.0 сая төгрөг, төмс, хүнсний тариалж байгаа 2 иргэнд үр болон тоног төхөрөмж худалдан авахад дэмжлэг болгон нийт 9.5 сая төгрөгийг тус тус шийдвэрлэж дэмжлэг үзүүллээ. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Бизнес эрхлэгчдийн аймгийн зөвлөгөөн"-ийг Өндөрхаан хотноо зохион байгуулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн, “FPM” ХХК-ниас болон орон нутгийн	10



	50%	3			1		2													
	30%	72	3	11	2	4	2	2	2	6	4	2	10	7	2	5	7	2	1	
	10%	23	3	4	1	1			1				1	2	1	1	2		1	5
Хугацаа болоогүй		-																		
Тасарсан		-																		
Орон нутгийн түвшинд биелэлт гаргах боломжгүй		26		2	2		5	2			6			2			6			1
Биелэлтийн дүн		25,9	20	24,6	30	26	40	30	23,3	30	30	30	28,1	25,5	23,3	26,6	25,5	30	20	10

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ЗДТГ-ЫН ТЗУХ-ИЙН ХШҮ-НИЙ ТАСГИЙН  
МЭРГЭЖИЛТЭН Ш.ЖАВХЛАН